



БҮГД НАЙРАМДАХ НАМ

REPUBLICAN PARTY

2004 оны 03-р сарын 15-нд

№ 09

Улаанбаатар хот

БАГА ХУРЛЫН ТОГТООЛ

УИХ-ын 4 дэх удаагийн сонгуульд оролцох тухай.

Монгол улсын Сонгуулийн тухай хуулийн 19 дугаар зүйлийн 1, Бүгд Найрамдах Намын Дүрмийн Гуравдугаар зүйлийн 18.7-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. УИХ-ын 4 дэх удаагийн сонгуульд Бүгд Найрамдах Нам бие даан, сонгуулийн 76 тойрогт нэр дэвшүүлэн оролцох талаар Намын улс Төрийн Зөвлөлийн шийдвэрийг сайшаан баталгаажуулсугай.
2. 2004 оны УИХ-ын сонгуультай холбоотой бүхий л асуудлаар шийдвэр гаргах эрхийг Намын Улс төрийн Зөвлөлд шилжүүлсүгэй.
3. УИХ-ын 4 дэх удаагийн сонгуульд Бүгд Найрамдах Нам хэрхэн оролцсон талаар дэлгэрэнгүй тайлагнахыг Намын Улс төрийн Зөвлөлд үүрэг болгосугай.

Хурлын Дарга

Тэргүүлэгчид:



/Б.Жаргалсайхан/

УЛС ТӨРИЙН НАМУУ/ЫН ТҮХАЙ ХУУЛЬ

4 дүгээр зүйл. Намын үйл ажиллагааны үндсэн зарчим

Нам үйл ажиллагаандаа дор дурдсан үндсэн зарчмыг баримтгана.

а) Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийн дэглэлд сахин биелүүлэх;

б) эх орон, ард түмний нийлэгт эрх ашигт нийцүүлэн үйл ажиллагаа ял тоол явуулах;

в) бусад намын нэр төрийн хүндэтгэх, дотоод хэрэгт нь холбогдондос үл оролдох, гэнгээрт оорийн үзэл бодлыг дутган шаардахгүй байх;

д) оорийн морийн хөтөлбөороо нарийн тани сахин мориох;

ж) хямүүлэгт, ардчилсан элсрэлтгүй бөгд эрхэмлэн дээлгэх;

з) Монгол улсаас бусад оронтой тогтоосон найрамдал, хамтын ажиллагааг эрхэмлэн хүндлгэх

Handwritten signatures and notes in the left margin.

Монгол Улсын Дээд шүүхийн 20... 04... 4-р сарын 5-ны өдрийн 02р тогтоолоор

БҮГД НАЙРАЦЛАХ

Намид улсын бүртгэйд бүртгэйд



Handwritten signature of P. Jambayandorj.

Р.ЖАМБАНДОРЖИД
Н.ТӨРБЭЛТ
О.БАГИРАА

БҮГД НАЙРАМДАХ НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Бүгд Найрамдах Нам /БНН/ нь консерватив үзлийг үйл ажиллагааныхаа үзэл баримтлал болгосон барууны төвийн нам болно. Намын эрхэм зорилго нь бүтээлч, чинээлэг иргэнтэй, хүчирхэг эдийн засагтай, хүчтэй төртэй монгол улсыг байгуулахын төлөө тэмцэх явдал бөгөөд нам энэ зорилгоо хэрэгжүүлэхдээ “ Монгол хүнийг анхаарлынхаа төвд байлгаж түүнд аяъяас билгээ хөгжүүлэх, бүтээлч шударга хөдөлмөрөөрөө хувийн өмчөө арвижуулж үндэснийхээ баялагийг нэмэгдүүлж, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийг шинэ түвшинд гаргах боломж олгоно”

Энэ утгаар БНН нь УИХ-ын 2004 оны сонгуульд “**Бид боломж олгоно, Та бүтээж чадна**” гэсэн уриатай оролцож байна. Нам өнөөгийн жирийн монгол хүний нийтлэг дүр төрх, монголын ард түмний аж амьдрал, монголын улс төр, эдийн засаг, нийгмийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч улс гэрээ өөд татах мөрийн хөтөлбөрөө боловсруулан ард нийтэд толилуулж байна.

Монгол хүний нийтлэг дүр төрх, ард түмний аж амьдрал

Угсаа чанараараа “Монгол хүн” нь авъяаслаг сэргэлэн эх оронч хүн боловч түүнд энэ гайхам чанараа ашиглаж улс орноо хөгжүүлэх боломж ардчилал зах зээлд шилжсэн сүүлийг арав гаруй жилд олдоогүй юм. Энэ хугацаанд жирийн монгол хүний хөдөлмөрийн үнэлэмж буурч, амжиргааных нь өртөг өндөрсөж “ядуу хүн” болж хувирсан.

Эргэн тойрондоо ажилгүйдэл, архидалт, ядуурал, гэмт хэрэг, хээл хахууль, хүнд суртал, ёс суртахууны доройтол, баян ядуугийн огцом ялгаа гарч алхам тутамдаа шударга бусаар хөрөнгөжих, хуулийг үл тоох явдалтай учирч байгаа. “Жирийн монгол хүн”-ий урам хугарч төр засагтаа итгэхээ больжээ.

Энэ хугацаанд ялангуяа манай эрэгтэйчүүдийн нийгэмд болон өрх гэрт эзлэх байр суурь онцгой доошиллоо. Үүний шалтгаан нь ямар ч бэлтгэлгүйгээр цэрэг армия үлэмж цомхотгож, боловсруулах үйлдвэр, барилга, авто тээвэр, газар тариалан зэрэг техникийн мэргэжилтэй эрэгтэйчүүд олноор ажилладаг үйлдвэр, аж ахуйн газруудыг эрсдлээс хамгаалах ямар нэгэн арга хэмжээ авалгүйгээр хувьчилснаас, мөн ихэвчлэн эрэгтэй хүүхдүүд суралцдаг техник мэргэжлийн сургуулиуд үүд хаалгаа барьснаас эрэгтэйчүүд олноороо ажилгүй болсон явдал гэж үзэж болно. Цэргийн болон техникийн мэргэжилтэй эрэгтэйчүүд лангууны ард зогсож, ломбард ажиллуулж, үсчин гоо сайхны үйлчилгээ эрхлэхгүй нь ойлгомжтой. Ажилгүй болсон эрэгтэйчүүдээс цөөнгүй нь “архи”-тай нөхөрлөж улмаар энэ муу үзэгдэл нийгмийн шинжтэй болж өсвөр насны эрэгтэй хүүхдүүд болон залуу эрэгтэйчүүдийн амьдралын хэв маягт зохиогүй нөлөө үзүүлсэн нь гэмт хэрэг нэмэгдэх болсон нэгэн шалтгаан болно. Сүүлийн үед гадаад хэл, эдийн засаг, хүмүүнлэгийн ухааны чиглэлээр байгуулагдаж байгаа сургуулиуд нь ихэнхдээ эрэгтэй хүүхдийн сонирхол татахгүй байгаа нь тэдний “боловсролгүй хүн” болоход нөлөөлж байна. Эрэгтэйчүүдийн энэ доройтол нь нийгэмд олон сөрөг үр дагавар авчирч байгаагийн дотор хамгийн ноцтой нь пүүс, компаниудад техникийн мэргэжилтний ажиллах хүч дутагдаж байгаа явдал юм. Түүнчлэн гэр бүл салах үр хүүхэд өнчрөх явдал жил бүр нэмэгдээд зогсохгүй эмэгтэйчүүдийн дунд ажил амьдралаа хүнтэй суухгүйгээр зохицуулахыг хүсэгчид төрж эхэлсэн нь таатай үзэгдэл огтхон ч биш юм. Хүн амын ангиллаар авч үзвэл эмэгтэйчүүд, эхчүүд, хүүхэд, ахмад настан, тахир дутуу иргэд бүгд “хуульчлагдсан нийгмийн хамгаалал”-тай, олон улсын конвенцтой, төрийн бодлоготой, эрх ашгийг нь хамгаалсан байгууллагатай байхад 18-60 насны эрхтэн бүтэн эрэгтэйчүүд юу ч байхгүй байгаа нь тэднийг “шоовдорлогдсон хүмүүс” гэж хэлэх нэгэн үндэслэл болж байна. Улс орны хувь заяаг эрэгтэйчүүдээс салгаж авч үзэх аргагүй бөгөөд

энэ утгаар урагшгүй төрийн харалган бодлогын золиос болсон эрэгтэйчүүдэд улс орон өрх гэрээ эр хүний ёсоор авч явах боломж олгох шаардлагатай байна.

Нийт ард түмний аж амьдарлыг авч үзвэл өнөөгийн үнэ ханшаар тооцож үзэхэд ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүн амьжиргааныхаа хэвийн хэрэгцээг хангахад дунджаар сарын 300 мянган төгрөгний орлоготой байх шаардлагатай байна. Гэтэл манай төсвийн байгууллагын ажилтны сарын дундаж цалин 40 мянган төгрөг улсын хэмжээний дундаж цалин 89.3 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас олгож буй өндөр настны сарын дундаж тэтгэвэр 34.7 мянган төгрөг, халамжийн тэтгэвэр 14.4 мянган төгрөг, амьжиргааны баталгаажих доод түвшин Улаанбаатарт 26.5 мянган төгрөг, баруун бүсэд 20.2 мянган төгрөг, зүүн бүсэд 21.2 мянган төгрөг, хангайн ба говийн бүсэд 20.6 мянган төгрөг байна. Нийт хүн амын 40% буюу нэг сая хүн ядуу ба нэн ядуу амьдарч байна. Ингэж манай хүн ам нийтээрээ ядуу, хөдөлмөр эрхэлж байгаа хэсэг нь "бага орлоготой" байгаа нь бараа үйлчилгээ худалдан авах чадваргүй буюу амьдрал нь чанаргүйг харуулаад зогсохгүй "хүн ам бага орлоготой байх нь эргээд бизнесээ дэмждэггүй"-г нотолж байна. Энэ байдлыг өөрчлөх зайлшгүй шаардлагатай бөгөөд уг асуудлыг шийдвэрлэхэд хэрэгцээтэй санхүүгийн нөөцийг дотоодын эх үүсвэрээс гаргах боломжтой.

Монгол орны улс төр, эдийн засаг нийгмийн байдал

Монгол орон ардчилал, зах зээлийн тогтолцоонд шилжих гэж 14 дэх жилийнхээ нүүрийг үзэж байна. Энэ хугацаанд шинэ "Үндсэн хууль"-аа баталж, төрийн эрх барих байгууллагын болон ерөнхийлөгчийн сонгуулийг тус бүр 3 удаа хийж "шилжилт" хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх болон зах зээлийн зарчмаар аж ахуйгаа эрхлэхтэй холбогдсон зарим арга хэмжээ авч ирсэн. Энэ 14 жилийн дотор улс орон улам хөгжин дэвжих ёстой байсан атал эсрэгээр ад түмний аж амьдал доройтолд орж, улс орны эдийн засаг олон жилээр ухарч байна. Энэ нь "шилжилт, шинэчлэлт" зөв хийгдэхгүй байгаа буюу Монгол улс буруу явж байгааг нотолж байна.

- УИХ-ын 1992 оны сонгуульд МАХН, 1996 оны сонгуульд МҮАН, МСДН-ын "Ардчилсан холбоо эвсэл", 2000 оны сонгуульд МАХН ялсан боловч энэ нь үнэн хэрэг дээрээ төрийн эрх мэдэл нэрүүд нь өөр боловч үйл ажиллагаагаараа нэг их ялгаагүй нэг бүлэглэлээс нөгөө бүлэглэлд шилжсэн шилжилт байсан. Нийгмийн зүгээс энэ 2 бүлэглэлийг "АХ эвсэл асуудлыг бүдүүлэг хар хүч, гэмт аргаар шийдвэрлэдэг" гэж, "МАХН нь аливаа асуудлыг шийдвэрлэхдээ коммунист арга хэрэглэдэг, айж эмээх, бялдуучлах, удирдагчаа мухар сохроор тахин шүтэх нь газар авсан" гэж тус тус дүгнэсэн. Хэдийгээр энэ хоёр хүчин ажлынхаа арга барилаар ийм ялгаатай ч УИХ-ын гишүүний суудал, засгийн газрын албан тушаалыг хувьдаа ашиг хонжоо олох хэрэгсэл гэж үздэг нийтлэг чанартай. Энэ хоёр бүлэглэлийн парламент, засгийн газрын цөөнгүй гишүүдийн эрх зүй, эдийн засаг, нийгмийн талаархи мэдлэг сул дорой, ажил хэрэгч зарчимч чанар дутмаг, ёс зүйд ач холбогдол өгдөггүй, эрх мэдэл албан тушаалаа хуулийн дээр тавих нь түгээмэл байсны зэрэгцээ иргэд төрийн бус байгууллагууд тэдний үйл ажиллагаанд хяналт тавих боломж байгаагүй. Энэ бүгдээс үзэхэд өнгөрсөн 14 жил манайд парламент өчүүхэн ч төлөвшсөнгүй. Үүний нотолгоо нь "АХ эвсэл"-ийн "Таны итгэл бидний зүтгэл" гэрээ биелэгдээгүйгээр үл барам хожмоо тэд "Бид ард - түмэнтэй ямар ч гэрээ байгуулаагүй" гэж мэлзсэн, МАХН-ын сүүлчийн сонгуулиар ард түмэндээ өгсөн "Төрөө хямралаас гаргая, түмнээ ядуурлаас аваръя" амлалт биелээгүй явдал болно.
- Төрийн өмчийн үйлдвэрийн газрыг хувьчлахдаа дампууруулж эсвэл дампуурлын ирмэгт аваачиж хувьчилсан. Хувьчилсны дараа ямар ч үр ашиг шаардаагүй, дөнгөж шинээр бий болсон компаниудаа дэмжиж зах зээлийг

хамгаалахын оронд торгож шийтгэн, мөнгө нэхэж дарамтлах, зах зээлийг нь хааж гадаадын чанар муутай бүтээгдэхүүн оруулах зэргээр үндэсний үйлдвэрлэгчиддээ өсөн дэвжих боломж олгохгүй байгаагаас эдийн засаг уналтанд орсон. Ингэж эдийн засаг уналтанд орсоноос төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн эцсийн жил болох 1989 оны түвшингээс даруй 10-12 жилээр ухарлаа. Өнгөрсөн 10-аад жилд уналт үргэжилж, сүүлийн 4 жил бага зэргийн өсөлт гарч байгаа боловч энэ нь бодит үр ашигтай өсөлт хөгжилт биш, зөвхөн уналтын түвшингийн ойрын зайнд эргэлдэж буй идэвхигүй хөдөлгөөн мэт агуулгатай байсаар байна.

- Америк долларын төгрөгтэй харьцах ханш жилээс жилд унасаар бараг 1200 төгрөг болсон нь төрийн мөнгөний бодлого зөв бишийг харуулж байна. Өргөн хэрэглээний үндсэн нэрийн бараа бүтээгдэхүүн ажил үйлчилгээний үнийн өсөлт нь хүн амын орлогын өсөлтөөс түрүүлсэн хэвээр байгаагаас ядуу, нэн ядуу амьдралтай хүн ам 10 саяд хүрсэн нь 1996 оны түвшингээс даруй 2 дахин нэмэгдэж, нийт хүн амын 1/3-с давлаа.
- Орон нутгийн төсөв бүхэлдээ алдагдалтай байгаа төдийгүй төвлөрсөн төсвийн алдагдал түүхэнд байгаагүй дээд хэмжээ 100 гаруй тэрбум төгрөгөөс ч давах болов.
- Өөрийн орны эдийн засгийн үндэс болсон хөдөө аж ахуйн түүхий эдээ үндсэн нь гүн боловсруулж, олон нэр төрлийн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон улсын болон дотоодын зах зээлд нийлүүлдэг байсан үндэсний үйлдвэрлэл зогсож, мөхөлд орсон нь улсын түүхэнд байгаагүй ажилгүйчүүд гэдэг шинэ сөрөг үр дагавар бий болгож, энэ нь өнөөгийн хүн амын ядуурал, нийгмийн доройтлын үндэс болж байна.
- Улс төрийн хямрал, эдийн засгийн уналтаас үүдэлтэйгээр хүн ам, түүний дотор хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн ёс зүй, ухамсарын түвшин доройтож нийгэмд элдэв гэмт хэрэг зөрчил нэмэгдэж байна.
- Нийгмийн хөгжил дэвшлийн үндэс болсон хүн амын боловсрол, эрүүл мэнд доройтож хүний хөгжлийн үндсэн үзүүлэлт уналтанд орсоор байна. Тухайлбал, хүний хөгжлийн үзүүлэлтээр манай орон 1990 онд дэлхийн 175 орноос 70 дугаарт орж байсан бол 1998 оны байдлаар 101-д орох болтлоо ухралтанд орлоо.
- Гадаад орнууд, олон улсын санхүүгийн байгууллагууд манай орны шилжилт, өөрчлөлтийг хүндэтгэн олон талын дэмжлэг туслалцаа үзүүлж байгаа ч түүнийг улс орны эрх ашигт үр ашигтайгаар бүтээлчээр ашиглах явдал туйлын хангалтгүй байна. Гадаад орнуудаас авсан зээл тусламж бараг тэрбум долларт хүрч байгаа нь манай улсын жилд үйлдвэрлэж байгаа дотоодын нийт бүтээгдэхүүнтэй, 3 жилийн экспортын орлогын хэмжээтэй үндсэндээ тэнцэж байгаа нь улс орны эдийн засгийн чадавхи баталгаагүй байдлалд орсныг харуулж байна.
- Иргэдийн амь нас эрүүл мэндийг хохироох, өмч хөрөнгийг хулгайлах, дээрэмдэх гэмт хэрэг улам харгис хэрцгий шинжтэй болж байгаа, түүнчлэн төр нийгмийн зүтгэлтний амь насыг хөнөөсөн хэрэг илрэхгүй удаарширч буй нь нийгэм хэр зэрэг доройтсоныг харуулж байна.
- Радио, телевиз өдий болтол төрийн мэдэлд байгаа нь иргэд, түүний дотор хөдөө орон нутагт оршин суугчдад зөвхөн нэг талын, төр засгийн үйлдлийг зөвтгөсөн, удирдлагыг хоосон магтсан мэдээлэл цацагдах хэрэгсэл болж ардчилалыг хөгжүүлэхэд саад болсоор байна.

.....

Монгол орны амьдралын энэхүү ээдрээт байдалд дүгнэлт хийж Монгол орноо хөгжүүлэх, тусгаар тогтнол, хүн амын амьдрал, соёл боловсрол, эрүүл мэндийг хамгаалах, хөгжүүлэхийн төлөө БНН улс монголынхоо төлөө чин сэтгэлтэй иргэдтэй хамтран эрчимтэй ажиллахаар УИХ-ын 2004 оны сонгуулийн нэн хариуцлагатай үйл ажиллагаанд оролцохоор эрүүл саруулаар ухаарч, бүтээлчээр бэтгэж монголын ард түмний төлөө юу хийх хэрэгтэйгээ биелэгдэх эдийн засгийн баталгаатай нь дараахи байдлаар тодорхойлон дэвшүүлж байна:

Хөгжил дэвшлийн зорилт, түүний үндсэн агуулга

- Ардчилал, шударга ёс, тэгш эрх, хариуцлага сахилга, ёс зүйн дээд зэргийн шаардлагад нийцсэн улс төрийн нэр хүндтэй, шудрага үйл ажиллагаа явуулна.
- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн 12-15 жилээр ухарсан өнөөгийн уналт, сүйрлийг зогсоож, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт болох дотоодын нийт бүтээгдэхүүний бодит хэмжээг 1989 оны оргил үеийн төвшингөөс нэмэгдүүлж, дундаж өсөлтийг 6-10 хувьд хүргэн шинэ зуунд эрчимтэй хөгжлийн бодит өсөлт бий болгох баттай нөхцөл бүрдүүлнэ.
- Шүүх засаглалын үйл ажиллагааг шудрага, бодит хуулийн шаардлагад нийцсэн байдлаар өөрчлөн, хүн бүр хуулийн өмнө тэгш эрхтэй байх, үүргээ биелүүлэх, эрхээ эдлэх, хуулийг дээдлэх зарчмыг төлөвшүүлнэ. Аливаа хуулийн энэрэнгүй, нигүүлсэнгүй байх зарчмыг шудрага байх зарчимтай зөв хослуулахыг чухалчилна.
- Улс орноо гэсэн эх оронч сэтгэлтэй, шударга ёс, хөдөлмөрийг эрхэмлэн дээдэлдэг Монгол хүн нь монголын төрийн ивээл халамжинд байх ёстой үнэт баялаг, улс орон тусгаар тогтнолоо хамгаалан орших, төр байхын утга учир хэмээн үзнэ.
- Төрийн нэрийн өмнөөс нийгмийг удирдан жолоодож явах төрийн болон төсөвт байгууллагын албан хаагчдын орлогыг нэмэгдүүлэх, амьдралыг нь дээшлүүлэхийг онцгойлон үзэж, ажлын бүтээл, сахилга хариуцлага, ёс зүйн өндөр шалгуураар сард 300 мянган төгрөгийн цалин авах нөхцөл боломжийг үе шаттай баталгаажуулна.
- Монгол орон оршин тогтнож, хөгжин дэвших материаллаг үндэс нь эцэг тэнгэр, эх газраас заасан олон зуун жилийн уламжлалтай, хорвоод ховорхон хэв шинж бүхий хөдөө нутаг, тэнд жилийн дөрвөн улиралд хөдөө хөхөрч, гадаа гандаж, хоёр нарны хооронд борви бохис хийхгүй бие сэтгэлийн тэнхээ мэдэн ажиллаж амьдардаг, уужуу тайван, ухаалаг, төрийн хүндэтгэлийг эхлэн эдлэх эрхтэй малчин, тариаланч ард гэж үзэн хөгжил, төрийн халамж, нийгмийн бодлогын асуудлыг хөдөө нутгаас эхлэнэ. Монгол орны хөдөө нутгийг хөгжүүлэх, хөдөөгийн хүн амыг амьдралыг дээшлүүлэхэд чиглэгдсэн 11 бүлэг бүхий хөдөөгийн хөгжлийн иж бүрэн бодлого хэрэгжүүлнэ.
- Үндэсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэхэд бодитой алхам хийнэ.
- Шинжлэх ухаан, боловсролын тогтолцоог улс орны гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллуулна.
- Хүн амын амьдралыг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэхэд чиглэгдсэн цогцолбор бодлого хэрэгжүүлнэ.
- Хүн амын эрүүл мэндийг хамгаалах асуудлыг онцгойлон анхаарч материаллаг нөхцлийг бүрдүүлнэ.
- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн талаар дэвшүүлж байгаа зорилтоо хэрэгжүүлэхэд чиглэгдсэн нийгмийн болон төсөв, санхүү, мөнгөний бодлогын эрүүл, дэвшилттэй нөхцөл, эрх зүйн шинэ орчин бий болгоно.

- Улс орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүн амын тайван амьдрах нөхцлийг баталгаажуулах, Олон улсын хэмжээнд өөрийн орны нэр хүндийг хамгаалахад чиглэгдсэн дэвшилттэй үйл ажиллагаа явуулна.

1. Намаас хэрэгжүүлэх үндсэн зорилт, үйл ажиллагааний ерөнхий чиглэл

1.1 Монгол орны хөгжлийн стратеги нь :

- Хүний эрх, эрх чөлөөт байдлыг хүндэтгэн дээдлэж, ардчилалд үндэслэгдсэн улс төрийн боловсронгуй тогтолцоотой, төрийн зохицуулалттай зах зээлийн зарчимд тулгуурласан, экспортод чиглэсэн, харьцангуй биеэ даасан эдийн засагтай, экологийн үндсэн тэнцвэр хадгалсан, оюуны багтаамж бүхий технологийн шинэ орчинд тулгуурласан, эрчимтэй хөгжил бүхий үйлдвэржсэн орон болгох
- Дэлхийн хамтын нийгэмлэг, бүс нутгийн улс орнуудтай харилцан ашигтай, хамтран ажиллах, байгаль орчны ерөнхий доройтол, нийтийг хамарсан эмгэг гамшгаас урьдчилан сэргийлэх, түүний үр дагаварыг хамтын хүчээр гэтлэн давах, найдвартай тогтолцоог бий болгох явдал юм.

1.2 Хөгжлийн эх сурвалж, үндсэн зорилго:

Монгол орны хөгжил дэвшлийн үндсэн зорилго нь :
Эх орон, үндэсний тусгаар тогтнол, шудрага үнэний төлөө шинэ эрмэлзлэлтэй, оюун соёлын өндөр түвшинтэй, эрүүл саруул бие бялдартай, чинээлэг боловсон амьдралаа өөрийн шудрага хөдөлмөрөөр бий болгохын төлөө хөдөлмөрийг эрхэмлэн дээдлэгч Монгол хүнийг төлөвшүүлэх явдал юм.

1.3 Хөгжлийн стратеги, зорилтыг хэрэгжүүлэх үндсэн арга, үйл ажиллагааны чиглэл:

Стратегийн зорилтыг хэрэгжүүлэх гол арга зам нь :

- Төрийн ухаалаг зохицуулалт, оновчтой зохион байгуулалт, бүтцийн зөв сонголт, нарийвчилсан төлөвлөлт, хүн бүрийн ухамсартай, идэвхитэй хөдөлмөр эрхлэлт, хуулийг хүндэтгэн сахих, хатуу сахилга, шудрага байдал гэж үзнэ.
- БНН аливаа хөгжлийн асуудлыг авч үзэхдээ эдийн засгийн макро түвшингийн хандлагыг харгалзахаас гадна эдийн засгийн бүсчиллийн тэнцвэртэй хөгжлийн шаардлагыг тэргүүн ээлжинд анхаарч төрийн мөнгө, санхүү, нийгэм, эдийн засаг, хуваарилалт, зохицуулалт, хяналт, мэдээлэлжүүлэлт, дэмжлэгийн бодлогын хөдөөг онцлох хэрэггүй. Энэ буруу.

Хүн бүр хөдөлмөрлөн амьдрах нөхцлийг бүрдүүлж, нийгмийн хэрэгцээт оюуны болон материаллаг баялагийг монгол хүний оюун ухаан, хөдөлмөрөөр бий болгох нь төрийн бодлогын үндсэн зорилт гэж үзнэ.

2. Мөрийн хөтөлбөрийн үндсэн бүтэц

2.1 Монгол төрийн байгуулал ба ардчилал

Хүн бүрийн тэгш эрх, ардчилсан төрт ёсны мөн чанарыг дээдлэн хүндэтгэсэн, улс төрийн боловсронгуй тогтолцоо зөв бүтэц, сахилга хариуцлагын өндөр зарчимд түшиглэсэн парламентийн засаглалыг үйл ажиллагааг бүхий л талаар хэрэгжүүлэхийг эрмэлзэнэ.

- Улс төрийн болон гүйцэтгэх засаглалын ажилтны хариуцлага, сахилга, дэг журам, ёс зүйн хэм хэмжээнд тавих хяналт, шаардлагыг өндөржүүлэн, хариуцлага тооцох эдийн засаг, эрх зүйн нөхцөл бүрдүүлэхийн зэрэгцээ, үзэл бодол, намын харъяалал, нас, хүйс, шашин шүтлэгээр нь ялгаварлахгүй, гагцхүү мэдлэг чадвар, ажлын хариуцлага, ёс зүйн хүмүүжил, ажлын бүтээлийг нь харгалзан хөдөлмөрийн үнэлэмжинд тохирсон, урамшуулал, цалин хөлстэйгөөр ажиллуулах зарчмыг гол шалгуур болгоно.
- УИХ-ын гишүүнээр сонгогдох хүний улс төр, эдийн засаг, хууль зүйн боловсрол, ёс зүйн төлөвшил, улс орны амьдрал байдалд үнэлэмж дүгнэлт өгөх чадвар, эх оронч, хүнлэг, хөдөлмөрч чанар, зан харилцааны соёл зэрэг нь УИХ-ын хэвийн ажиллах, улстөрийн төлөвшилтийн үндсэн нөхцөл, энэ нь улстөрийн тогтвортой байдлын баталгаа, нийгэм зөв хөгжих хөрс суурь болно гэж үзнэ. Энэ шалгуураар УИХ-ын гишүүнд нэр дэвших хүмүүсийн бүтцийг бий болгоно.
- Үндсэн хууль, УИХ-ын Сонгуулийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалыг тухай хууль гэх мэт нийтийн эрх ашгийг хамарсан түгээмэл, онцгой хуулиудад өөрчлөлт оруулах, шинээр боловсруулахдаа парламентийн гаднах улс төрийн болон төрийн бус байгууллагууд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагын төлөөллийг оролцуулах, хуулийн төсөлд олон түмний санал авах зэргээр ардчиллын зарчмыг харгалзах байр суурь баримтална.
- Төрийн тогтолцоо бүрдүүлэгч засаглалуудын эрх мэдлийг нарийвчлан тодорхойлж, тэдгээрийн харилцан үйлчлэлийн зохистой механизм бүрдүүлнэ.

2.2. Гүйцэтгэх эрх мэдэл

- Засгийн газрын бодлогын залгамж чанарыг хадгалахын зэрэгцээ эдийн засаг, нийгмийн, стратегийн, цаг үеийн зорилтыг уялдуулан тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих, зохицуулах ажиллагааг сайжруулахын тулд эдийн засгийн прогнозчилал, төлөвлөгөөт зохицуулалтын аргыг чухал гэж үзнэ. Нутаг дэвсгэрийн түвшинд хүн амын зайлшгүй хэрэгцээт зүйлийн хангамжийг зохих түвшинд нь байлгах, үнийн хэт өсөлт бий болгохгүй байхад чиглэгдсэн төрийн зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлнэ.
- Төр, засаглалын байгууллагад ажиллагсадыг улс төрийн албан тушаалтны багаар бүрдүүлэх, гадуурхах, хомрогolon чөлөөлөх, нас хүйс, нутаг орноор ялгаварлах зэрэг гаж буруу хандлагаар бүрдүүлэхгүй, зөвхөн мэргэжил, ажлын чадвар, хариуцлага, ёс зүй, албан тушаалын болон иргэний соёл, хүмүүжлийн төлөвшил, ажлаа ухамсартай, хариуцлагатай хийх, авилгал хээл хахууль авахгүй байх сэтгэлийн тэнхээтэй байх, хөдөлмөрийн сахилга батыг сахих чадвар зэрэг хүний төлөв байдлыг гол шалгуур болгоно.
- Гүйцэтгэх эрх мэдэлд улс төрийн нэг намын ноёрхол, илүү шат дамжлага, эдийн засгийн болон материаллаг сонирхол, хүнд суртал, бусдад чирэгдэл учруулдаг, дарамталдаг, хууль бус шаардлага тавьдаг байдлыг хориглож,

энэ чиглэлээр ямар нэгэн илрэл гарсан тохиолдолд хариуцлага, шаардлагын хатуу журам мөрдөнө.

- Засгийн газар, яам, агентлагууд, хотын удирдах, гүйцэтгэх албан тушаалтныг намуудын шилдэг төлөөллөөр бүрдүүлэхийг гол зарчим болгоно.
- Төр засгийн удирдах албан тушаалтан, ажлаас чөлөөлөгдсөн нөхцөлд хангамж, эрх ямба эдлүүлэх, хүндэтгэл үзүүлэх эсэхийг үзэмжээр биш, албан тушаалын ажил үүргээ гүйцэтгэж чадсан эсэхийг нь харгалзан шийдвэрлэдэг байхаар эрх зүйн шинэ орчин бүрдүүлнэ.

2.3. Нутгийн удирдлага

- Ардчилалын зарчмаар зохион байгуулагдаж, хариуцлагын өндөр түвшинд үйл ажиллагаагаа явуулах, нутгийн өөрөө удирдах ёс, түүний бие даасан байдлыг хүндэтгэн дээдлэж холбогдох эдийн засаг, нийгэм, эрх зүйн нөхцлөөр хангана.
- Орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон засаглалын байгууллага нь нутаг дэвсгэрийн хөгжил, хүн амын амьдралын тусын тулд эдийн засаг, нийгмийн зөв орчин бий болгохийн төлөө нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөх татвар, санхүүгийн зохицуулалт /тодорхой хэмжээнд/ хийх эрх эдэлж болох зарчмыг баримтлана.
- Орон нутгийн хөгжил, үйл ажиллагаа, хөдөөгийн хүн амын амьдралын төлөө хариуцлагын өндөр түвшинд бие дааж үйл ажиллагаа явуулах боломжоор хангахын тулд орон нутгийн төсвийн орлого, зарлагын тэнцвэрийг хангахад чиглэгдсэн санхүүгийн нөөц бүрдэлт, зарлага санхүүжилтийн бодлого хэрэгжүүлнэ.
- УИХ-ын чуулганаар батладаг одоо ч батладаг үргэлж ийм байсан.
- Аймаг, хотын ИТХ өөрийн батласан орон нутгийн төсвөө Сангийн яам болон УИХ, Засгийн газарт албан ёсоор тогтоосон хугацаанд ирүүлдэг байхаар эрх зүйн шинэ орчин бүрдүүлнэ.

2.4. Мэдээлэл, сурталчилгаа

- Монголын үндэсний телевиз радиог олон нийтийнх болгож, хувийн сувгийг орон нутагт тэнцвэртэй гаргах арга хэмжээ авна.
- Хүн ам, ялангуяа, хөдөөгийн хүн амд үнэн бодит мэдээлэл хүргэх, төрийн хууль, цаг үеийн зорилтуудыг сурталчилах, хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих, иргэд, орон нутгийн байгууллагад ажиллагсадын санал хүсэлтийг судалж, төрийн бодлоготой уялдуулах талаар бодитой, тодорхой шинэ хэлбэрийн алхам хийнэ. Үүний тулд төрийн хууль тогтоомж, засаглалын үйл ажиллагааны цаг үеийн зорилтыг хөдөө орон нутаг, иргэд олон түмэнд сурталчилан таниулдаг, хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьдаг, ажил хэргийн тусалцаа үзүүлдэг, төрийн нэрийн өмнөөс олон түмэнтэй ажилладаг, төр-олон түмнийг холбосон төрийн суртал нэвтрүүлэгчийн байнгын ажиллагааны бүтцийг парламентийн дотор бий болгоно.
- Төсөв, татвар, цалин тэтгэвэр, гааль, гадаад харилцаа, шүүх эрх мэдэл, хөдөлмөрийн статистикийг хөгжүүлж, үндэсний мэдээллийн үзүүлэлтүүдийн хамрах хүрээг өргөтгөх, тооцоолох арга зүйн бодит байдлыг дээшлүүлэх чиглэлээр үндэсний статистик үзүүлэлтийн бүтцэд өөрчлөлт хийнэ.
- Хүн амын боловсролыг дээшлүүлэх, оюуны чадавхи сайтай, дадлагатай хүмүүсийн санаачлан бүтээл туурвих, төр нийгэмд хэрэгцээтэй чухал асуудлыг боловсруулах сэтгэлгээг хөгжүүлэх боломж хангах үүднээс улс орны хэмжээний үзүүлэлтийн мэдээллийн хүрээг өргөтгөнө.

- Хүн амд бодит мэдээлэл хүргэж, төр олон түмний холбоог бэхжүүлэхэд бүх шатны ялангуяа сум, дүүрэг, баг хороодын Засаг дарга, хэвлэл мэдээллийн албадын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх нь чухал гэж үзнэ.
- Үндэсний мэдээлэл нь төр, засгийн байгууллагын хэрэгцээнд зориулагдах төдийгүй хүн амын боловсролын хэрэгцээнд зориулагдан ашиглагдах, эдэлж ашиглах ёстой оюуны өмч гэж үзнэ.
- Хүн амын боловсролыг дээшлүүлэх, амьдрах арга ухаанд суралцуулах зэргээр мэдээллээр хангахад радио, телевиз, компьютерийн болон интернэтийн сүлжээний сүүлийн үеийн техник хэрэгслэлийн хангамж, түүнд хамрагдах хүрээг нэмэгдүүлнэ.

2.5 Шүүх эрх мэдэл

- Нийгмийн бүх хүрээний үйл ажиллагаанд гарч байгаа аливаа зөрчлийг арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд бодитойгоор шударга үйлчилж чадах хуулийг боловсруулж, баталгаажуулан мөрдөх, түүнийг сурталчлан таниулж, хэрэгжилтэнд нь хяналт тавих нь хууль боловсруулах гол утга агуулга, сонголтод онцгой анхаарна.
- Шүүх, хууль хяналтын байгууллагын материаллаг нөхцлийг сайжруулна.
- Хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байх, хуулийг дээдлэх зарчмыг хэрэгжүүлж, хууль зөрчсөн хэн ч болов хариуцлага хүлээдэг зарчимд шилжинэ.
- Нэгэнт гарсан шүүхийн шийдвэр заавал биелэгдэж байхаар заасан хуулийн заалтыг жинхэнэ утгаар хэрэгжүүлэхтэй холбогдсон эрх, үүрэг, үйл ажиллагааны шинэ хэлбэр бий болгож мөрдүүлнэ.
- Иргэдийн өмч хөрөнгийг хулгайлсан, хүний амь насыг санаатай хохироосон, зэрлэг балмадаар дарамталсан, доромжилсон, айлган сүрдүүлж заналхийлсэн, ой, мод байгалийн баялаг, цахилгаан болон телефон холбооны хэрэгсэл, шугам сүлжээ гэх мэт нийтийн түгээмэл хэрэглээтэй эд зүйл хулгайлсан гэмт этгээдэд хүлээлгэх ялын бодлогыг чангатгана, иргэдийн мэдээлэл авах шинэ нөхцөл бий болгоно.
- Хүний амь насыг хохироосон, албан тушаалаа ашиглан хээл хахууль авсан, хууль зөрчсөн төрийн албан тушаалтанд ямар нэг өршөөл үзүүлэх байдлаар ял хөнгөлөхийг бүрэн хориглоно.
- Үүргээ биелүүлсэн нөхцөлд эрхээ эдлэх эдийн засгийн баталгаа бий болно гэсэн зарчмаар ард иргэдийн эрхээ эдлэх, үүргээ биелүүлэх үйл ажиллагааны харилцан хамаарлыг хангахын төлөө хуулийн суртал нэвтрүүлгийн ажлын хүрээг өргөтгөж, ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургууль, коллежийн болон албан байгууллагын хүрээнд зохион байгуулагдах мэдээлэл, сурталчилгааны ажлын программд тусгах нь чухал гэж үзнэ.

2.6. Монгол хүн, хөдөлмөрийн нөөцийн хөгжил

Хүн төрөлхтний хөгжлийн дэлхий нийтийн үзэл баримтлалын шаардлагад нийцүүлэн хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, эрүүл байж урт наслах, эрдэм боловсрол эзэмшиж, шударгаар хөдөлмөрлөн боловсон чинээлэг аж төрөх нөхцлийг бүрдүүлэх нь Монгол хүн, хөдөлмөрийн нөөцийн хөгжлийн талаар төрөөс баримтлах гол бодлого байх болно.

Энэ хүрээнд хүн амын категори тус бүрээр тусган хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ.

2.6.A. Боловсрол

Өндөр түвшингийн боловсрол, мэргэжил бүхий иргэд нь нийгмийн болон хувь хүний аж амьдралыг дээшлүүлэх хамгийн анхдагч гол хүчин зүйл болно гэж үзнэ. Олон улсын түвшинд хүрсэн техник, технологийн, эдийн засгийн боловсролтой бизнесменүүд, онол, практикийн тодорхой мэдлэгтэй, ухаалаг, зөв чиг баримтлалтай улс төр, нийгмийн зүтгэлтэн, инженер техникийн тодорхой чиглэл бүхий дээд боловсролтой ажиллах хүч, тэргүүн зэргийн боловсролтой бүтээлч, эрдэм шинжилгээний ажилтан, соёл урлагийн зүтгэлтэн, техник мэргэжлийн чиг баримжаа, сонгон суралцах онцгой авъяас чадварт тулгуурласан бүрэн, бүрэн бус дунд боловсролтой өсвөр үеийг төлөвшүүлэх нь боловсролын талаар төрөөс баримтлах гол бодлого, нийгмийн хөгжлийн гол хэрэгцээ гэж үзнэ.

Эх оронч үзэл, үндэсний бахархал, өндөр боловсрол, бие даан өөрийгөө хөгжүүлэх чадвар, хөдөлмөрч бүтээлч зан чанарыг төлөвшүүлэхэд сургалт хүмүүжлийн ажлыг чиглүүлж, бүх шатны сургалтын агуулга, бүтэц, арга зүйг нийгмийн хэрэгцээнд тохируулан өөрчилнө.

Үүний тулд:

- Суурь боловсролыг үнэ төлбөргүй эзэмшүүлнэ.
- Техник мэргэжлийн боловсрол эзэмших, хөдөлмөрийн дадлага, мэдлэг, чиг баримжаатай болгох зорилтыг эдийн засгийн үр ашиг, амьдралын хэрэгцээ зэргийг харгалзан ерөнхий боловсролын дунд сургуульд суралцах хугацаанд нь эзэмшүүлнэ.
- Боловсрол эзэмших эдийн засгийн нөхцөл, материаллаг боломжийг нь бүрдүүлэхийн тулд боловсролын даатгалын сан, хувь хүний сайн дурын хандив, аж ахуй нэгж, байгууллагын болон төрийн дэмжлэгийг хослосон бүтэц бүхий даатгалын тогтолцоог үе шаттай хэрэгжүүлнэ.
- Хүүхдийг 6-7 настайгаас нь эхлэн сургуульд суралцуулах зорилтыг нийтээр дагаж мөрдөнө.
- Ерөнхий боловсролын дунд сургуульд суралцах хугацааг 11 жил болгож, 1-8-р ангид бүрэн бус боловсрол, 9-11-р ангид бүрэн дунд боловсрол эзэмшүүлэн, 7-8-р ангид суралцах хугацаанд нь мэргэжлийн анхан шатны чиг баримжаа, дадлага боловсрол эзэмшихээр, 9-11-р ангид нь техник мэргэжлийн боловсрол эзэмших чиглэлээр сургалтын программд нь бүтцийн шинэчлэлт хийнэ.
- Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, сургуульд орох бэлтгэл хангасан байхаар сургалт, хүмүүжлийн ажлын дэвшилттэй агуулга, бүтэц бий болгоно.
- Мэргэжлийн коллеж, их, дээд сургуулийг бүсчилсэн байдлаар зохион байгуулж ажиллуулна.
- Аймгийн төв болон бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдсан их, дээд сургууль, мэргэжлийн коллежид суралцаж байгаа оюутан, суралцагчидад даатгалын сангаас зохих хэмжээний тэтгэлэг олгох боломжийг хэрэгжүүлэхийг зорино.
- Соёл урлаг, биеийн тамирын салбарыг төрийн ивээлд байлгаж, түүх, соёлын дурсгалт зүйл, музейн сан хөмрөгийг арвижуулах, сэргээн засварлах, хамгаалах, олон улсын хэмжээнд сурталчилах чиглэлээр хөрөнгө оруулалт хийх санхүүжилтийн бусад чиглэлийг дэмжин жил бүр холбогдох төсвийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ.

2.6.B. Эрүүл мэнд

“ Эрүүл биетэй, саруул ухаантай, сурч хөдөлмөрлөх чадвартай хүнийг төлөвшүүлэх, эх нялхсын эрүүл мэндийг хамгаалах, элдэв халдварт ба халдварт

бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчилгээ үйлчилгээний чанарыг сайжруулж, түүний баталгаажилтыг хангах, чирэгдэл хүндрэл багатай, тохилог орчин бүрдүүлэх нь эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах гол бодлого байх болно. "

- Одоо ажиллаж байгаа эмнэлэг, сувилалын байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, засвар үйлчилгээ хийх, орчин үеийн дэвшилттэй техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслэлээр хангах, шаардлагатай газарт зориулалтын байр бий болгох чиглэлээр орчин нөхцлийг нь сайжруулна.
- Бүс нутгийн байршлыг харгалзан аймаг дундын нэгдсэн болон төрөлжсөн, нарийн мэргэжлийн эмнэлэг, төвүүдийг зохион байгуулж бололцоотой бүх чиглэлээр олон төрлийн эмчилгээ, үйлчилгээ хийж чаддаг байхаар ажиллуулна.
- Эмчилгээ оношлогооны олон төрлийн зориулалттай, орчин үеийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, дадлага туршлагатай, өндөр боловсролтой эмч нараас бүрдсэн хөдөлгөөнт үйлчилгээгээр хөдөөгийн хүн ам, ялангуяа зах хязгаар нутаг, алслагдсан сумын иргэд, малчдад үйлчилгээг үзүүлэх ажлыг зохион байгуулна.
- Эрүүл мэндийн даатгалын сангийн эх үүсвэр бүрдүүлэх, төсвийн ачааллыг хөнгөлөх эдийн засгийн суурь орчин бий болгоно. Хөдөлмөрийн чадвартай иргэн бүр заавал буюу сайн дурын даатгалд бүрэн хамрагдах эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- Дотоодод үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх бололцоотой эм, эмийн барааны импортод хязгаарлалт тавих, импортоор авч байгаа болон дотоодод үйлдвэрлэгдэж байгаа эм, эмийн барааны чанарт тавих хяналтыг сайжруулна.
- Сум, багийн эмчилгээ, үйлчилгээг өрх бүрт тогтмол хүргэхийн тулд техник хэрэгсэл, материаллаг нөхцлөөр хангах, ялангуяа өндөр настан, бага насны хүүхэд, жирэмсэн буюу төрсөн эхчүүдэд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээг тогтмолжуулах чиглэлээр өрхийн эмчийн ажиллах, цалинжих үйл ажиллагааг уялдуулан, хариуцлагын өндөр түвшинд хийж гүйцэтгэх шинэ нөхцөл бүрдүүлнэ.
- Хүн амын ундны ус болон хүнсний хангамжийн асуудлыг онцлон үзэж хүрэлцээтэй, чанартай, эрүүл ахуйн баталгаатай байлгахад чиглэгдсэн бодлого хэрэгжүүлнэ.
- Эхчүүдийн төрөх байрыг сэргээн тохижуулах, шинээр бий болгох, түргэн тусламжийн машин, эмийн үйлчилгээгээр хангах ажлыг зохион байгуулна.

2.6.В. Хүн амын ахуй амьдрал, түүний чанар

" Биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас " гэсэн үндэсний уламжлалт мэргэн сургаалийн агуулгыг мөрдлөгө болгон сурч боловсрон, мэдлэг эзэмшсэн хүн эрүүл төлөвшсөнөөр биеэ авч явах эхний нөхцөл бүрдэнэ. Амьдралын хэрэгцээт зүйлээ өөрийн хөдөлмөрөөр бий болгох нь иргэн хүн тав тухтай, боловсон амьдрах, төр түвшин амгалан байх нөхцөл гэсэн зарчмыг баримталж дараахи арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Хүн амыг тохилог орон сууцаар хангах, орон сууцны нөхцлийг сайжруулах, ялангуяа залуу гэр бүлийг хүссэн орон байраа өөрсдийн хөдөлмөрөөр бий болгох, захиалгаар үйлчилгээ хийлгэх санаачлагыг нь дэмжин санхүүгийн хөнгөлөлт, бусад материаллаг дэмжлэг үзүүлнэ.
- Урт хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох замаар хүн амын орон сууцны хангамж нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлнэ.

- Монгол хүний нүүдлийн соёл иргэншилд зохицсон, шаардлагатай үед зөөвөрлөн тээвэрлэх боломжтой тохилог дулаан, монгол гэрийг ахуйдаа хэрэглэх боломжийг нэмэгдүүлнэ. Иж бүрдэл бүхий гэр орон сууц, түүний эд ангийг хөнгөлөлттэй үнээр болон зээлээр олгох үйл ажиллагаа зохион байгуулна.
- Хүнсний болон өргөн хэрэглээний зарим гол нэрийн барааг дотооддоо үйлдвэрлэж, чанар сайтай үндэсний үйлвэрлэлийн бараагаар дотоод зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлэх, чанар, эрүүл ахуй, хэрэглээний шаардлага хангахгүй импортын бараанаас зах зээл, хүн амын эрүүл мэндийг хамгаалах бодлого хэрэгжүүлнэ. Үүний тулд дотооддоо үйлдвэрлэх боломжтой импортын барааны гаалийн болон нэмэгдсэн өртгийн татварыг нэмэгдүүлэх зэрэг эдийн засгийн хөшүүргийн үйлчлэлийг оновчтой болгоно.
- Хүн ам, өрхийн ахуйн соёл дээшлүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа, бодлого хэрэгжүүлнэ.
- Төв хөдөөд саун, халуун усны үйлчилгээг бий болгохыг дэмжиж, энэ чиглэлээр бизнес эрхлэгчдэд санхүүгийн туслалцаа үзүүлнэ.
- Хүн амын амьдралын баталгааг хангах үндсэн нөхцөл болсон цалин хөлсний шинэ агуулгатай, харьцангуй өндөр хэмжээтэй, нийгмийн баримжаатай бодлого хэрэгжүүлж, цалин хөлсний өнөөгийн тогтолцоог үндсээр нь өөрчилнө. Үүний тулд цалин хөлсний хэмжээг газар зүйн байршил, экологийн нөхцөл, зах зээлд оролцох боломж, хөдөлмөрийн агуулга, нийгмийн бодлого зэргийг харгалзан төсөвт байгууллагын ажиллагсадын сарын дундаж цалинг 2004-2008 онд үе шаттайгаар төрөөс зохицуулан 300 мянган төгрөгт хүргэх бодлого хэрэгжүүлнэ.
Ингэхдээ шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгчид болон шинжлэх ухааны байгууллагад ажиллагсадын цалинг түлхүү нэмэгдүүлнэ.
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахинаас доошгүй хэмжээгээр нэмэгдүүлнэ.

2.7. Эдийн засгийн бодлого

- Микро эдийн засгийн хөгжлийг төлөвшүүлэх замаар макро эдийн засгийн тогтворжилт, цаашид хөгжих боломж нөхцөл, баттай суурь хангах нь эдийн засгийн чиглэлийн гол чиглэл байх болно.
- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн уналт, ухралтыг зогсоож, эдийн засгийн бодит хэмжээг 1989 оны оргил үеийн түвшингээс нэмэгдүүлж жилийн дундаж өсөлтийг 6-10 хувьд хүргэж цаашид эрчимтэй хөгжүүлэх баттай нөхцөл бүрдүүлнэ.
- Төрийн эдийн засаг, нийгмийн бодлогын үндсэн чанарын болон зарчмын шинэ агуулгатай, бодит үр дүнтэй, зөв чиглэлтэй өөрчлөлт хийж төрийн зохицуулалтын механизмын үйлчлэлийг тодорхой болгоно. Үүнд:
- Шинэ агуулга, зорилготой харьцангуй өндөр хэмжээтэй, хүн амын амьдрал, эдийн засаг, нийгмийн агуулгатай олон чухал асуудлыг хөндөн үр өгөөжтэйгөөр, тодорхой харагдахуйц хэмжээгээр шийдвэрлэж чадах цалин хөлсний шинэ бодлого хэрэгжүүлнэ. Үүнд:
 - Төрийн өмчийг хувьчлан хувийн өмчид шилжүүлэх байдлаар биш нэгэнт бий болсон буюу шинээр бий болох хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг дэмжин хөгжүүлэх замаар нийт эдийн засагт хувийн хэвшлийн эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ.
 - Стратегийн болон түгээмэл хэрэглээний зориулалттай бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ хийдэг төрийн өмчийн аж ахуйн нэгжийг бэлтгэл

хангахгүйгээр яаран хувьчлахгүй, харин түрүүчийн хувьчлагдсан аж ахуйн нэгжүүд хуулийн болон болзлын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд, үр дүн нь ямар байгаад үзлэг шалгалт хийж, төрийн хяналт тавих нь чухал гэж үзнэ.

- Үндэсний үйлдвэрлэлээ дэмжин сэргээх, шинээр бий болгон хөгжүүлэх, импортыг хязгаарлах, экспортын үйл ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор мөнгө, зээл, санхүү, татварын уян хатан зохицуулалт хийнэ. Импортын, гаалийн өндөр татвар, дотоодын үйлдвэрлэлийн хөнгөлөлттэй татварын орчин бүрдүүлж дотоод зах зээлээ хамгаалсан шинэ орчин бий болгоно.
- Татварын бодлого, татвар ногдуулалтанд татвар төлөгчийн үйл ажиллагааг дэмжсэн, тэдний эрх ашиг, төсөв бүрдүүлэлт, улс орны эдийн засгийн хэрэгцээ, сонирхолын нэгдлийг зөв хослуулсан байх зарчмыг баримтална.
- Төрийн зүгээс хүн амын орлого нэмэгдүүлж, амьдралыг нь дээшлүүлэх зорилгоор цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдүүлэх арга хэмжээнд сэргөөр нөлөөлөх байдлаар үнэ тарифыг зохиомлоор хөөргөдөн, инфляци, унийн өсөлт бий болгодог байдлыг зогсоохын тулд түгээмэл хэрэглээний нэрийн бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ тарифыг бодит өртөг, ашигт ажиллагааны зохих түвшинд нийцсэн байдлаар унийн зөрүүгийн татвар авдаг журам, аргачлал, эрх зүйн орчин бүрдүүлэх нь чухал гэж үзнэ.
- Экспорт, импортын бараанд ногдуулах гаалийн татварыг зөв хувилбараар тогтоох байдлаар гадаад худалдааны тэнцвэржилтийн нөхцөл бүрдүүлэх, цаашид ашигтай ажиллах бүх талын боломж бий болгон улмаар төлбөрийн тэнцлийг сайжруулна.
- Нийт эдийн засагт / дотоодын нийт бүтээгдэхүүний үйлвэрлэлд / аж үйлдвэр, хөдөө аж ахуйн салбар зонхилох хувь эзэлсэнээр эдийн засгийн бодит салбарын бүтцийн зөв хандлага бий болгоно.
- Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн үндсэн тэнцвэрийг зөв хандлагад оруулж, эдийн засгийн тогтворжилт, цаашдын эрчимтэй өсөлтийн зөв бүтэц хөрс суурь бий болгоно. Үүнд:
 - Нийт эдийн засаг дахь салбарын бүтэц / нийт эдийн засгийн бодит салбарын эзлэх хэмжээ түүний дотор аж үйлдвэр, хөдөө аж ахуйн давуутай байх шалгуурыг баримтална /
 - Хэрэглээний сангийн дотоод бүтэц, үндсэн тэнцвэр / хэрэглээний сан дахь Засгийн газрын хэрэглээний зохисгүй өсөлтийг хязгаарлана /
 - Хэрэглээ хуримтлалын үндсэн тэнцвэр /хүн амын амьдрал, нийгмийн хэрэглээний өсөлтийг хангах, хэрэглээний сангийн өсөлт, улс орны хөрөнгө оруулалтын дотоод эх үүсвэрийн тууштай өсөлтийг хангах эдийн засгийн нөхцлийг бий болгоно /
 - Ашиглагдах нөөцийн зөв бүтэц, үндсэн тэнцвэр / ашиглагдах нийт нөөцөд өөрийн нөөцийн эзлэх хэмжээ, өсөлтийг нэмэгдүүлэх, гадаад нөөцийг зориулах объектийг зөв сонгох, үр өгөөжийг дээшлүүлэхийг чухалчилна /
 - Гадаадын зээл тусламжийн нийт хэмжээ, экспортын орлогын болон дотоодын нийт бүтээгдэхүүний зохистой харьцаа, үндсэн тэнцвэрийг төрийн хяналтанд байлгана.
 - Тухайн жилд гадаад орон, олон улсын байгууллагаас авах зээл тусламж нь мөн хугацааны экспортын орлогоос илүүгүй байх, авч ашигласан зээл тусламжаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр ашгаар зээл төлөлтийн эх үүсвэр бий болгох бодлого хэрэгжүүлнэ.

- Төсвийн орлого, зарлагын үндсэн тэнцвэрт хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авна.

2.8. Үндэсний үйлдвэрлэл, аж үйлдвэрлэлийн бодлого

Монгол орны эдийн засаг, нийгмийг XXI зуунд түүний дотор 2005-2009 онуудад тогтвортой хөгжүүлэх анхдагч нөхцөл нь үндэсний аж үйлдвэрийн хөгжлийн бодлогыг төрийн анхаарлын төвд тавьж, төрийн зохицуулалттайгаар улс орны нийтлэг хэрэглээг эхлэн хангах чиглэлээр аж үйлдвэрлэлд дэд салбарын оновчтой сонголт, шийдэлтэйгээр эрчимтэй хөгжүүлэх явдал мөн гэж үзнэ.

- Хүн амын ахуй амьдрал, ахуйн соёл, үйлдвэрлэл, эдийн засаг, нийгмийн хөгжлийн анхдагч нөхцөл нь болсон эрчим хүчний хэрэгцээг өөрийн орны үйлдвэрлэлээр хангах зорилтыг үндэс болгож, тус салбарыг түлхүү хөгжүүлэх бодлого баримтална.
- Уул уурхайн салбарын талаар төрөөс баримтлах бодлогыг “Аливаа улс орон эх нутгийхаа хөрсөн доор ямар баялагтайгаараа биш, харин түүнийг хэрхэн зөв ашиглаж, боловсруулж байгаагаараа өөрийн давуу талыг баталгаажуулна” гэсэн шалгуураар тодорхойлно. Уул уурхайн аж үйлдвэрлэл нь манай улсын экспортод тэргүүлэх түвшинд хэвээр байх хэтийн чиглэлийг харгалзан цэвэршүүлсэн алт, коксжуулсан нүүрс, боловсруулсан газрын тос, боловсруулалт хийгдсэн мөнгө, төмөрлөг бүтээгдэхүүн, баяжуулах буюу эцсийн боловсруулалт хийгдсэн аливаа бүтээгдэхүүн нь уул уурхайн салбарын хөгжлийн хамгийн гол хэмжүүр байх болно гэж үзэж эрдэс баялагийг олборлох-боловсруулах-баяжуулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийг эзэмшсэн олон улсын түвшинд өөрийн давуу талыг бий болгох зорилт тавина. Байгалийн баялаг, эрдэс түүхий эдийг хаягдалгүй буюу хаягдал багатайгаар иж бүрэн ашиглах, байгалийн нөөц хомсдох тусам түүний төлбөр өсч, байгаль, экологи, газрын хэвлийг хэрэглэгч, бохирдуулагч нь хариуцдаг байх тогтолцоог бүрдүүлнэ.
- Төмөрлөгийн үйлдвэртээ үйлдвэрлэсэн хайлшаа ашиглан мал аж ахуй, хөнгөн хүнсний үйлдвэрт түгээмэл хэрэглээтэй импортын бага оврын тоног төхөөрөмж, тэдгээрийн хийц, хэсгийг үйлдвэрлэн импорт хэмнэж, цаашид экспортын эх үүсвэр бий болгох нөхцөл бүрдүүлнэ.
- Шахмал түлш үйлдвэрлэж дотооддоо хэрэглэх, нүүрсийг коксжуулан экспортлох бодлого баримтална.
- Алт нь байгалийн нөхөн сэргээгдэхгүй үнэт баялаг, дэлхийн улс орнуудын мөнгөний алтан баталгаа, улс орны эдийн засгийн хүч чадавхийг илэрхийлэгч онцгой төрлийн таваар, эд баялаг мөн тул төрийн бодлогын анхаарлын төвд байх ёстой гэж үзнэ. Алт олборлолт, боловсруулалт, борлуулалт, байгаль экологийн хамгаалалт зэргийг харилцан уялдаатай авч үзэж алт олборлосноос шалтгаалж байгалийн гамшиг үзэхгүй байхаар хамгаалалтын “тэнцвэр хадгалах бодлого” хэрэгжүүлнэ.
- Барилгын материалын зориулалттай эрдэс, түүхий эдийн нөөцийг оновчтой ашиглах, мэргэшсэн ажилчин, инженер, техникийн ажилтан бэлтгэх, давтан бэлтгэх арга хэмжээ авна.

- Цемент, тоосго, хөнгөн болон төмөр бетон, шохой, эрдэс болон тосон будгийн хэрэгцээг бүсчилсэн байдлаар хангах бодлого баримталж, хэрэгжих нөхцлийг бүрдүүлнэ.
- Мал аж ахуй, газар тариалангийн гаралтай түүхий эдийн үндэсний нөөцийг технологийн өндөр түвшинд монгол хүний оюун ухаан, хөдөлмөрөөр гүн боловсруулж, үндэсний үйлдвэрлэлээ сэргээх, шинээр үүсгэн хөгжүүлэх замаар оюуны багтаамж сайтай, дээд зэргийн чанартай, олон нэр төрлийн, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж олон улсын зах зээлд өөрийн давуу талыг бий болгох бодлого хэрэгжүүлнэ. Үүний тулд:
 - Мал аж ахуйн гаралтай, стратегийн ач холбогдолтой зарим төрлийн түүхий эд / ноолуур, хонь ямааны арьс, үхэр адууны шир, хонь тэмээний ноос гэх мэт/-ийн экспортыг хязгаарлан үндэсний үйлдвэрлэлд нийлүүлэх бодлого баримтална. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд олон улсын гэрээ, хэлэлцээрийн шаардлагад харшлахгүй байх, мөн түүхий эдийг иргэд байгууллагаас авч үйлдвэрлэл явуулж байгаа аж ахуйн нэгж нь өмчийн төрөл, аль улсын харъяалалтайгаас үл хамааран Монгол Улсын төрийн зохицуулалт, төсвийн хуулийн өмнө адил тэгш үүрэг хүлээхэд чиглэгдсэн байхаар санхүүгийн хөшүүргийн үйлчлэлийн зөв орчин бүрдүүлнэ.
- Гурил, гурилан бүтээгдэхүүн / төрөл бүрийн печень, нарийн боов, өрмөнцөр / ундаа, давс, ногооны консерв, хивс, хивсэнцэр, ноосон болон хагас ноосон даавуу, сүлжмэл эдлэл, гутал, архи, пиво, эм, эмийн бараа гэх мэт дотоодод үйлдвэрлэх бараа бүтээгдэхүүнд сонголт хийж, түүнтэй ижил төрлийн бараа бүтээгдэхүүнд импортын өндөр татвар ногдуулах, өөрийн үйлдвэрлэлийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
- XXI зууны эхний жилүүдэд түүний дотор 2005-2009 онуудын түвшинд дараах объектуудад ач холбогдол өгч гадаад дотоодын хөрөнгийн эх үүсвэрээр барьж байгуулах, ашиглалтад оруулах, бэлтгэл хангах нь чухал гэж үзнэ. Үүнд:
 - Сэлэнгэ аймгийн Төмөртэйн ордыг ашиглаад төмрийн хүдэр ашиглах замаар Дарханы хар төмөрлөгийн үйлдвэрийг түүхий эдээр хангах / 2006 оноос /
 - Эгийн голын УЦС-ыг барьж байгуулах / 2008 оноос /
 - Завханы фосфоритын ордыг эзэмших / 2007 оноос /
 - Тавантолгойн коксжих нүүрсний ордыг эзэмшин, кокс экспортлох
 - Сүхбаатар аймгийн цайрын ордыг эзэмших
 - Баян-Өлгийн Асгатын мөнгөний ордыг эзэмших / 2008 оноос /
 - Улаанбоомын УЦС-ыг барьж, ашиглах
 - Эрдэс түүхий эдийн одоогийн ашиглаж байгаа нөөцийг үргэлжлүүлэн ашиглахын зэрэгцээ, уран, өнгөт болон холимог металлын шинэ ордыг эзэмших
 - Газрын тос олборлолтыг нэмэгдүүлэн боловсруулалт хийж, импортыг хэмнэнэ.

2.9. Дэд бүтэц

Эрчим хүч, зам гүүр, тээвэр холбоо зэрэг дэд бүтэц бүрдүүлэх нь аливаа хөгжлийн материаллаг нөхцөл мөн гэж үзэн төрийн зохицуулалттайгаар хөгжүүлэх бодлого баримтална.

2.9.А. Эрчим хүч

- Хөдөө сумдын эрчим хүчний хэрэгцээг хангах, үйлдвэрлэл үйлчилгээ явуулах боломж бүрдүүлэхийн тулд зардал багатай, байгаль орчиндоо халгүй, нар, салхины, усны гэх мэт сэргээгдэх эрчим хүч, дизель станц зэргийг хослуулан ашиглах, төвийн болон бүс нутгийн эрчим хүчний системтэй холбох замаар сумдын эрчим хүчний хэрэгцээг хангах зорилтыг 2006 он хүртэлх хугацаанд бүрэн хэрэгжүүлнэ.
- Газрын тос боловсруулах үйлдвэрийг цахилгаан станц бүхий цогцолборын хамт байгуулснаар эрчим хүчний импортыг тэглэж, төлбөрийн болон гадаад худалдааны тэнцэл сайжруулах боломж бүрдүүлнэ.
- ОХУ-аас Монголын нутгаар дамжуулан Хятад, Өмнөд Солонгос, Япон улсууд хийн хоолой тавих нь манай орны эдийн засагт ач холбогдолтой гэж үзэн хамтран ажиллах бодлого баримтална.
- Эрчим хүчний салбарт бүтцийн шинэчлэлт хийх замаар үйлдвэрлэх, борлуулах, дамжуулах үйл ажиллагааны бие даасан болон эрчим хүчний хангамжийн найдвартай байдлыг хангах нь өрийн сүлжээг багасгах, хэрэглээ, төлбөр тооцооны оновчтой сонголт хийх боломж бүрдүүлнэ гэж үзэн онцгой анхаарна.

2.9.Б. Зам, тээвэр

Хөдөөгийн хүн амын, ялангуяа баруун бүс нутгийн хүн амын амьдралыг дээшлүүлэх, тэднээс зах зээлд оролцох боломжийг хангах, хэрэгцээт бараагаа аль болох богино зайнаас тээвэрлэх, бүс нутгийн жигд хөгжлийн шаардлагыг хангахад хот хоорондын болон аймаг төвөөс хилийн дамжлага бааз хүртэлх замыг сайжруулах нь чухал гэж үзэн хатуу ба хайрган хучилттай замаар холбох зорилтыг хөрөнгийн боломжийг харгалзан 2005-2009 онд барьж дуусгах зорилт тавина. Энэ ажлыг цэргийн албаны үүргээ дүйцүүлэх албаны байдлаар хаах сонирхолтой тухайн аймгийн залуучууд, хугацаат цэргийн албаны хүмүүс, оюутан суралцагсадын болон мэргэжлийн байгууллагын хүчээр хэрэгжүүлэх нь чухал гэж үзнэ. Замын ажилд оролцсон оюутан, суралцагчидын хөдөлмөрийн хөлсний зохих хувийг өөрсдөд нь өгч, үлдсэн хувийг төвлөрүүлэн, боловсрол болон хөдөө аж ахуйг эрсдэлээс хамгаалах санд зориулах бодлого баримтална.

- Монголын нутаг дэвсгэр дээгүүр Европ, Азийг холбосон авто тээврийн дээд зэрэглэлийн засмал зам, нефть дамжуулах хоолой тавих нь манай орны эдийн засагт ач холбогдолтой гэж үзнэ.
- Агаарын болон төмөр замын тээврийн найдвартай, үр ашигтай үйлчилгээг дэмжих, техник хэрэгслийг шинэчлэх, зам талбайг засварлах зэргээр үйлчилгээний ажлын чанар соёлыг олон улсын түвшинд хүргэнэ.

2.9.В. Харилцаа холбоо

- Орчин үеийн мэдээллийн сүлжээг өргөтгөн сайжруулах, хөдөөгийн хүн ам, түүний дотор малчдыг бага багтаамжтай реле, сансрын холбооны хөдөлгөөнт радио холбоогоор хангана. Харилцаа- Холбоо 2, 3 төслийн хүрээнд баруун, өмнө, зүүн, төв чиглэлийн аймгуудын холбооны техник хэрэгслэлийг шинэчлэх, дамжуулах байгууламжийг Висат сүлжээгээр холбох ажлыг эрчимжүүлнэ.
- Компьютерийн хангамжийг нэмэгдүүлэх, мэдээллийн нэгдсэн сангуудын төрлийг олшруулна.

2.10. Хөдөө аж ахуй

Монгол орны эдийн засаг, нийгэм, монгол хүний хөгжлийг XXI зуунд дэлхийн хөгжилтэй улс орнуудын жишигт хүргэхэд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлэх, хөдөөгийн хүн амын ахуй амьдрал, соёл боловсрол, нийгмийн нөхцлийг сайжруулах нь онцгой чухал гэж үзэж, төрөөс хөдөөд чиглэгдсэн төрийн дэмжлэг, зохицуулалтын иж бүрэн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үйлдвэрлэлийн, нийгмийн, төсөв санхүүгийн, дэд бүтцийн, ахуйн соёлын, цэргийн насны залуучуудын, газар тариалангийн, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрсдэлээс хамгаалах, мэдээлэлжүүлэлтийн, аюулгүй байдал, эрх зүйн орчны, аж ахуйн зохион байгуулалтын гэх мэт бие даасан бүтэцтэй иж бүрэн бодлого хэрэгжүүлнэ.

2.11. Төрийн мөнгөний бодлого

Банкны секторын үйл ажиллагаанд улс орны эдийн засаг, бүс нутаг, хүн амын амьдралд тодорхой үр ашиг, дэмжлэг өгөхүйц зах зээлийн эдийн засгийн зарчимд тулгуурласан, өөрийн орны онцлогт нийцсэн, санхүү эдийн засгийн үйл ажиллагааны дэвшилттэй чиглэл бүхий бүтэц зохион байгуулалт, эрх зүйн шинэчлэлт хийнэ. Үүний тулд:

- Банкны одоогийн тогтолцоог өөрчилж.
 - А. Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэгч Төв банк
 - Б. Улс орны болон бүс нутгийн хэмжээнд эдийн засгийн бүтцийн шинэчлэлт хийх, төвлөрсөн төсвийн орлого, зарлага, санхүүжилтийн үйл ажиллагааг дагнан хариуцдаг Монгол Улсын хөгжлийн буюу Төрийн үйлчилгээний / Засгийн газрын / банк
 - В. Хувийн болон бусад төрлийн өмчийн бүтэц бүхий нийтлэг болон төрөлжсөн үйл ажиллагааны чиглэлтэй арилжааны банк гэсэн шинэ тогтолцоонд шилжүүлнэ.
- Бүс нутгийн хөгжил, эдийн засгийн бүтэц, өсөлт, хүн амын өсөлт, нийгмийн нөхцөл, газар нутгийн байршил, үйлдвэрлэл, үйлчилгээний улирлын хамаарал зэргийг харгалзсан төрийн дэмжлэгийн чиг баримжаатай зээл хүүгийн ялгаатай уян хатан бодлого хэрэгжүүлнэ.
- Дэлхийн болон бүс нутгийн хөгжлийн банкуудтай хамтын ажиллагаа өрнүүлэх, экспорт-импортын болон хөгжлийн чиглэлээр зээл, санхүүгийн шинэ харилцаа хөгжүүлэх чиглэлийг дэмжиж зохих туслалцаа үзүүлнэ.
- Аливаа банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, шуурхай ажиллагааг дээшлүүлэх, хөдөөгийн хүн амыг бэлэн мөнгөөр хангахад чиглэгдсэн уян хатан тодорхой бодлого хэрэгжүүлнэ.
- Хувийн хэвшлийн болон хувь нийлүүлсэн банкны эрсдэл алдагдлыг татвар төлөгч ба төр хариуцдаг үйл ажиллагааг зогсооно.
- Байгууллага, иргэдийн хадгаламжийн баталгааг хангах, эрсдэлээс хамгаалахын тулд хадгаламжийн даатгалын тогтолцоог бий болгох нь чухал гэж үзнэ.
- Цаасан мөнгөний нийлүүлэлттэй холбогдсон уян хатан, шуурхай зохицуулалтын бодлого хэрэгжүүлнэ.
- Хөдөөд хийгдэж байгаа хонин хэлбэрийн тооцоо болон татварын солилцоог мөнгөн хэлбэрт оруулахад чиглэгдсэн зохицуулалт хийнэ.

- Хүнсний болон өргөн хэрэглээний бараа, нийгмийн ба ахуйн үйлчилгээний үнэ тарифыг үндэслэлгүй нэмэгдүүлж, инфляцийн зохиомол өсөлтийг бий болгож, амьдралын доройтлыг хэвээр хадгалахад хүргэдэг зохисгүй хандлагыг хязгаарлах бодлого хэрэгжүүлэх замаар төсөвт байгууллагын ажиллагсадын цалин, өндөр настны тэтгэвэрийг төрийн тодорхой бодлого, зохицуулалтаар нэмэгдүүлсний ач холбогдлыг алдагдуулдаг явдлыг зогсооно.
- Төгрөгийн гадаад валюттай харьцах, хөрвөх ханшийг зах зээлийн үнэ, дотоод зах зээлийн үнийн бодит харьцаанд үндэслэн тогтоож, шаардлагатай зохицуулалтын бодлого хэрэгжүүлнэ.
- Валютын биржийн үйл ажиллагааг эдийн засаг, зохион байгуулалтын дэвшилттэй хэлбэрт оруулна. Валютын зохицуулалтанд тавих төрийн хяналтыг сайжруулна.
- Зээл хүүгийн төлөлтийн календарчилсан график гаргаж, төсөвтэй уялдуулан хугацаанд нь төлж байхаар төрийн хяналтанд байлгана. Холбогдох санхүүгийн хөшүүрэг, үйл ажиллагааны оновчтой сонголт хийнэ. Тухайлбал, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр өргөтгөл, шинэчлэлт хийсэн, шинээр зохион байгуулагдсан аж ахуйн нэгжийн үндсэн хөрөнгийн элэгдлийг шимтгэлээс жил бүр зохих хувиар төлбөрийн фонд / сан / байгуулж, засгийн газрын банкинд төвлөрүүлэх боломжтой гэж үзнэ.

2.12. Төсөв, санхүү, татварын бодлого

- Төсвийн төвлөрлийг багасгаж, орон нутаг аль болохоор биеэ дааж ажиллах зарчмаар төсөв бүрдүүлэх талаар ИТХ-ын эрхийг өргөтгөх, тэгэхдээ Улсын Их Хурал, Засгийн газартай зөвшилцөх байдлаар төвлөрсөн хяналт, зохицуулалттай ажиллах чиглэл баримтлана.
- Төсвийн зарлага тооцох оновчтой нормативын арга хэрэглэн төсөв хэтрүүлэн зарцуулдаг байдлыг зогсооно. Санхүүгийн сахилгын хатуу зарчим тогтоож хэрэгжилтэд нь хяналт тавих Төрийн хянан шалгах хорооны эрхийг өргөтгөх нь чухал гэж үзнэ.
- Татвар ногдуулалт, хураалтын хариуцлага, үр дүнг дээшлүүлж, далд эдийн засаг, нуугдмал орлогыг бүртгэл мэдээлэлд хамруулна.
- Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний хэмжээ, татварын бааз нэмэгдүүлэх, татвар ногдуулалтын дэвшилттэй хэлбэр сонгох замаар татварын орлого нэмэгдэх, төсөв бүрдэлтийн зөв орчин бүрдүүлнэ.
- Улсын хэмжээнд үндсэн хөрөнгийн шинэчилсэн үнэлгээ хийж, паспортжуулах, даатгалын системд хамруулах ажлыг зохион байгуулна. Төрөл бүрийн даатгалын систем төлөвшүүлэх нь эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн баталгаа, төсөв бүрдүүлэлтийн үр ашигтай арга механизм гэж үзнэ.
- Төвлөрсөн болон орон нутгийн төсөв, татварын мэдээлэлжүүлэлтийн системийг сайжруулж, нэгдсэн бааз байгуулах, компьютерийг сүлжээнд холбох, шуурхай мэдээлэл, удирдлага, хяналтын асуудлыг онцгойлон үзнэ.
- Татварын ялгаатай бодлогоор бүс нутаг, үндэсний үйлдвэрлэл, хүн амын хэрэглээ, эдийн засгийн бодлогын уян хатан зохицуулалт хэрэгжүүлнэ.
- Төвөөс алслагдах тусам татвар ногдуулалт багасах, чиглэл баримтална.
- Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, үр ашиг, ашиглалтанд орох хугацаа, сонголтын талаар онцгой анхаарч, эх үүсвэрийн зөв бүтцийг бий болгохийг чухалчилна.
- Аливаа хөрөнгийн эх үүсвэрийг зах зээлийн эдийн засгийн үндсэн шаардлагын дагуу бий болгох, төсвийн сахилгыг хатуу сахих замаар

дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх Засгийн газрын хэрэглээг багасгах бодлого баримтална.

- Хөрөнгө оруулалтын дийлэнхийг үндэсний үйлдвэрлэл, эдийн засгийн бодит секторт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, дэд бүтэц, бүс нутгийн хөгжил, боловсрол, эрүүл мэндийн салбарт зориулах чиглэл баримтална.
- Төр доорхи чиглэлээр үнийн зохицуулалтын бодлого хэрэгжүүлнэ. Үүнд:
 - алслагдсан хязгаар нутгийн хүн амын амьдарлыг дээшлүүлэх, амьдралын өртгийн өсөлтөөс тодорхой хүрээнд хамгаалалт хийх
 - аж ахуй нэгж, байгууллага, жижиг үйлдвэр эрхлэгчдийг дэмжих.
- Төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг цахилгаан, дулаан, уур, усны зардал, байгууллага болон даатгуулагчийн хариуцдаг нийгмийн даатгалын шимтгэл, харилцаа холбооны зардал зэргийг оновчтой нормативчлах аргаар тооцон, төсвийн төлөвлөлтөнд тусгасан хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр үйлчлэгч, үндсэн байгуулагад нь шууд шилжүүлэх аргад шилжүүлэн санхүүжилтийн шуурхай байдлыг хангана. Мөн малын, боловсролын, хадгаламжийн, орон сууцны гэх мэт даатгалын хүрээг өргөтгөнө.

2.13. Хүн амын нийгмийн хамгаалалын талаар баримтлах бодлого, зорилт

Хүн амын нийгмийн хамгааллын асуудлыг “нийгмийн даатгал” “нийгмийн халамж” гэсэн үндсэн хоёр чиглэлээр шийдвэрлэх бөгөөд ингэхдээ иргэн хүн энэ хоёр тогтолцооны аль нэгэнд заавал хамрагдсан байхаар ажил, үйлчилгээг зохион байгуулна. Зах зээлийн нөхцөлд хүн амын нийгмийн хамгаалалд “нийгмийн даатгал” нь зонхилох байр эзлэдгийг иш үндэс болгож нийгмийн даатгалын салбарын хөгжилд түлхүү анхаарч, олон улсын түвшинд гаргах зорилгоор дараах арга хэмжээг бодлогоор хэрэгжүүлнэ:

- Мэдээлэл боловсруулах өндөр хүчин чадалтай цахим тооцоолуураар нийгмийн даатгалын байгууллагуудыг хооронд нь, мөн банк, эмнэлэг, иргэний бүртгэлийн болон бүх төрийн өмчийн шимтгэл төлөгч байгууллагуудтай холбоно.
- Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шударга, боловсронгуй болгоно. Энэ хүрээнд, эздээс шимтгэл авахдаа шимтгэл төлөх цалингийн хэмжээнд ямар нэгэн хязгаар тавихгүй тооцдог атал түүний ажилтанд тэтгэвэр, тэтгэмж тогтоохдоо хязгаар тавьсан цалингаас бодож олгодог, мөн эцэг, эх нь хоёулаа шимтгэл төлдөг байсан бүтэн өнчин хүүхдэд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоохдоо эцэг эх хоёрын цалингаас биш харин аль илүү цалинтай байсаных нь цалингаас тооцож олгох замаар эзэд, даатгуулагч, хүүхдийг хохироодог, мөн Үндсэн хуулийн цэцийн гишүүн байсан хүн нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоолгохдоо нийгмийн даатгалын хуульд заасан хувиар биш, “Үндсэн хуулийн цэцийн тухай хууль”-д заасан хувиар тогтоолгож давуу эрх эдэлдэг зэрэг хуулийн цөөнгүй шударга биш заалтуудыг эрх зүйн зарчимд нийцүүлэн өөрчилнө.
- Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн өмчийн харъяалалыг тогтоож дархлааг баталгаажуулна.
- Нийгмийн даатгалын байгууллагын эрх зүйн статусыг тодорхой болгож түүний өөрийгөө удирдах байгууллага болох Нийгмийн Даатгалын Үндэсний Зөвлөлийг ардчилсан зарчмаар ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

- Нийгмийн даатгалыг улс төрөөс ангид байлгах зорилгоор Нийгмийн даатгалын Үндэсний Зөвлөлийн гишүүдийг Монгол улсын Ерөнхийлөгч томилдог зарчимд шилжинэ.
- Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, гадаад орны хуулийн этгээд, иргэний болон олон улсын байгууллагын төсөл дээр, мөн төрийн бус байгууллагад ажиллагсадыг тэтгэвэрийн болон эрүүл мэндийн даатгалд хамруулна.
- Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх, санхүүгийн зах зээл дээр гаргах зэргээр ашиг олох боломжийг эрж хайна.
- Монгол улсыг Олон улсын нийгэм хангамжийн холбооны гишүүн улс болгоно.

Нийгмийн халамж

- Ахмад настан, тахир дутуу ирэгдэд үзүүлэх анхаарал, халамжийг нэмэгдүүлж үйлчилгээг боловсронгуй, үр дүнтэй болгоно.
- Төрөлтийг дэмжих, нялхасыг эрүүл чийрэг өсгөн бойжуулахад гэр бүлд туслах зорилгоор “хүүхэд асарсны тэтгэмж”-ийн хэмжээг доод цалингаар тогтоож уг мөнгийг зөвхөн хүүхдэд зориулах нөхцлийг бүрдүүлнэ.
- Өндөр настан, тахир дутуу иргэдийн асрамж үйлчилгээний чиглэлээр иргэдээс бизнес эрхлэх үйл ажиллагааг дэмжнэ.

2.14. Байгаль орчны талаар баримтлах бодлого, зохицуулалт

Улс орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, амьдралын болон эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах материаллаг нөхцөл нь газар нутаг, түүний баялаг, унаган төрхийг зөв ашиглах, хамгаалах, байгаль экологийн бүрэн бүтэн байдалтай зохицон амьдрах явдал мөн гэж үзнэ. Экологийн-эдийн засаг, экологийн-нийгэм гэсэн агуулгаар эдийн засаг, эрх зүйн шинэ нөхцлийг бүрдүүлнэ.

- Байгаль орчинд халгүй технологи хэрэглэх, хот суурин газрын ус, агаар хөрсний бохирдлыг бууруулах, ховор ан амьтныг нөхөн үржүүлэх, ойжуулах, усны нөөцийг арвижуулах, химийн хортой бодис, хог хаягдлыг байгаль, агаар орчинд хортой нөлөөлүүлэхгүйгээр устгах, ашиглах, азоны давхрагыг хамгаалах, хот суурин газрыг аянга цахилгаанаас хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийг шинжлэх ухааны үндэстэйгээр урьдчилан таньж мэдэх замаар байгалийн гамшигаас сэргийлэх, иргэдэд байгальтайгаа зохицон амьдрах чадварыг эзэмшүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг төрийн бодлогын төвд тавьж, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлж, тодорхой төлөвлөгөөтэйгөөр ашиглан, иргэдийг экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах зорилтыг хэрэгжүүлнэ.
- Байгаль хамгаалах хууль, дүрэм, журам зөрчсөн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад бодитойгоор хариуцлага тооцож хохирлыг барагдуулна.
- Газар эзэмших, хамгаалах сангийн эх үүсвэр, зарцуулалтанд хяналт тавих, хэрэгжүүлэх үйл ажиллагааны эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Бүтээгдэхүүн үнэ тариф нь байгаль экологийн хамгаалалт, ашиглалт, нөхөн сэргээхэд шаардагдах нийгмийн хэрэглээний өртгийг бүрэн тусгасан байх чиглэл баримтална.

- Улаанбаатар хотын усны эх үүсвэр, газар, ой модыг хамгаалах, нөхөн төлжүүлэх, зөв ашиглах арга хэмжээг төр, засгийн дээд түвшинд авч үзэж, эдийн засаг, эрх зүйн орчинг бүрдүүлж хэрэгжүүлнэ.
- Нийслэл хотын агаарын бохирдолтыг багасгах, бүрэн шаталттай, түлш бага хэрэглэдэг. Агаар орчинд хоргүй буюу хорт утаа, тоосжилт багатай зуухаар хангах ажлыг тусгай төслийн хүрээнд зохион байгуулна. Ядуу, нэн ядуу амьдралтай өрх болон 60-с дээш насны ахмад настанд тухайн төрлийн зуухыг үнэ төлбөргүй олгоно.

2.15. Аялал жуулчлал хөгжүүлэх чиглэл

Аялал жжлчлал хөгжих эрх зүйн орчинг бүрдүүлж, эдийн засгийн үр ашигтай, байгаль, эклогид сөрөг нөлөөгүй байдлаар хөгжүүлэхийг зорино. Энэ хүрээнд дэд бүтцийн өнөвчтой сүлжээг бий болгох, түүх, соёлын үнэт зүйлсийг сэргээн засварлах, хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авч аялал, жуулчлалыг байгалийн, сүвилалын, ангийн, түүх соёлын дурслагт газрын гэх мэт чиглэлээр төрөлжүүлж үйлчилгээг олон улсын түвшинд нийцсэн байхаар зохион байгуулахыг гол зорилго болгоно.

2.16. Өмч хувьчлал

- Эрчим хүч, төмөр зам, агаарын тээвэр, шуудан холбооны зарим объект, томоохон уурхайнууд, дэд бүтцийн чиглэлийн төрийн өмчийн болон түүний оролцоотой аж ахуйн нэгжүүдийг ойрын жилүүдэд хувьчлахгүй, харин эдгээрийн зах зээлд эзлэх байр сууриа бэхжүүлж өрсөлдөх чадварыг сайжруулна.
- Урьд нь хувьчлагдсан үнэ цэнэтэй аж ахуйн нэгж байгууллагыг хувьчилсан процессыг нягтлан шалгаж хувьчлагдсаны дараахи үйл ажиллагааг хувьчлахын өмнөхтэй нь харьцуулж үнэлэлт дүгнэлт өгч шаардлагтай арга хэмжээ авна.
- Иргэнд газар өмчлүүлэх ажиллагааг хатуу хяналтын дор явуулна.
- Гадаадын иргэн, хуулийн этгээд, харъяалалгүй хүнд газар ашиглуулах нь улс орны сан хөмрөгийг арвижуулах, газрын өгөөжийг нэмэгдүүлэх зорилготой байна.
- Иргэдийг хувийн өмчийнхөө газрыг үр ашигтай ашиглах арга барилд сургана.
- Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын ногоон бүс орчимд оршин сууж байгаа айлуудад газар эзэмшүүлэхдээ байгаль, экологийн нөхцөл, хүн амын усны хангамжинд сөргөөр нөлөөлөхгүй байх нөхцлийг гол шалгуур болгон тогтоон өгч, тодорхой хугацаагаар, тодорхой нөхцөлтэйгөөр газрыг ашиглах, хамгаалах үүрэгтэй байх эрх зүйн орчин бүрдүүлнэ.

2.17. Шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх чиглэл, зорилт

“Шинжлэх ухаан нь эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх гол хөшүүрэг” гэж үзэж байгалийн ухааны шинжилгээ судалгааны ажлын болон шинжлэх ухаан техник технологийн ололтыг бүтээндэхүүн үйлдвэрлэлийн практикт нэвртүүлэхэд, мөн өмчийн бүх төрлийн байгууллагын үйл ажиллагааг шинжлэх ухаанч арга барилаар удирдан зохион байгуулахад онцгой ач холбогдол өгнө. Энэ хүрээнд дараах арга хэмжээг авна.

- Шинжлэх ухааны туршилт хийх, судалгаа, шинжилгээний ажлын материаллаг баазыг бэхжүүлэх, шинээр бий болгоход улсын төсөвийн тодорхой хэсгийг зориулахыг хуульчилна.
- Монгол эрдэмтэд, судлаачдын оюун билэг, ур чадвар, бүтээлийг олон улсын хэмжээнд өргөнөөр сурталчилж шинжлэх ухааны гадаад харилцааг шинэ түвшинд гаргана.
- Хийгдэж буй болон хийхээр төлөвлөж буй судалгааны ажлыг бүртгэж улсын хэмжээнд шинжлэх ухааны нэгдсэн сан бий болгоно.
- Үйлдвэрлэл эрхэлдэг компани, аж ахуйн нэгж болон шинжлэх ухааны байгууллагын хамтын ажиллагааг баталгаажуулсан эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Дотоодын түүхий эдээр ажилладаг компаний бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулж гадаад зах зээлд гаргах үүднээс шинжлэх ухааны байгууллагад нийгмийн захиалга өгч ажиллуулна. Тухайлбал: хонины уртын ноос зөөлрүүлэх технологи бий болгож, даавуун материалын хэрэгцээг өөрийн үйлдвэрлэлээр хангах, нэг ямаанаас авах ноолуурын гарц, чанарыг нэмэгдүүлэх, гурилын гарц болон га-гийн ургацыг нэмэгдүүлэх, малын ашиг шимийг дээшлүүлэх, өндөр ашиг шимтэй мал өсгөх, байгалийн зүйлээр малын тэжээл бэлтгэх технологи, жор бий болгох захиалга өгнө.
- Шинжлэх ухааны байгууллагад бий болгосон ажлынхаа үр дүн, өгөөжийг өөрөө хүртэх боломж олгоно.
- Шинжлэх ухаан дэлхий нийтийн шинжтэй глобалчлагдаж байгааг харгалзан монгол орны шинжлэх ухаан, технологийн бодлого, зорилтыг улс орны хөгжил, хүн амын амьдралыг дээшлүүлэхэд чиглэгдсэн шинэ технологи, шинэ бүтээгдэхүүн бий болгох, өөрийн онцлог давуу талаа хадгалахын зэрэгцээ, дэлхийн шинжлэх ухааны хөгжилд өөрийн байр суурийг бэхжүүлэх, экспортын давуу байдал хангах, үндэсний элит сан бий болгож, нууцлалыг хадаглах зорилтыг хэрэгжүүлнэ.
- Өмчийн бүх төрлийн байгууллагаас шинжлэх ухааны үндэслэлтэй норм норматив, хөдөлмөр зохион байгуулалттайгаар ажиллахыг шаардана.

2.18. Хүүхдийн эрх, хөгжил, хүмүүжлийн талаар баримтлах бодлого, чиглэл

- Хүүхэд хамгаалах талаар дэлхий дахины тунхаглал, Монголын хүүхдийн үндэсний хөтөлбөрийн үзэл санааг чиг баримжаа болгон нийгэм, ахуй, хүмүүнлэг, сэтгэл зүйн хэрэгцээг онцгой анхаарч, хүүхэд асрах, эрхийг нь хамгаалах, өв тэгш төлөвшүүлэх, сургах, эрүүл бойжих, онцгой авъяас чадварыг нь хөгжүүлэх нөхцөл бүрдүүлж бодитой үйл ажиллагаа явуулах нь эцэг, эх, сургууль эмнэлэгийн байгууллага, төрийн хэрэг гэж үзнэ.
- Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхийг чухалчилна.
- Хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхэд / бүтэн өнчин, тахир дутуу, нэн ядуу, хараа хяналтгүй, садар самуун хүчирхийлэл, доромжлолын улмаас сэтгэл санааны бие махбодын хохирол хүлээсэн, орон гэргүй буюу тэнэмэл, гэр орноосоо дайжиж яваа хүүхэд /-ийг сургах, эмчлүүлэх, хөдөлмөрлүүлэх, тайван амьдрах нөхцөлтэй болгох, цаашид биеэ аваад явах хүмүүжлийн зөв төлөвшилтэй болгохын тулд тэдэнд зориулсан асрамж, амьжиргаа нийгмийн иж бүрэн нөхцөл бүрдүүлэхийн зэрэгцээ мэргэжлийн баримжаа, боловсрол олгохыг чухалчилна. Хүүхдийн кинотеатр, дэлгүүр, цэцэрлэг, ясли, номын сан, уншлагын танхим, пионөрийн зуслан, сувилал төрөх газар гэх мэт онцгой объектуудыг төрийн зохицуулалтын түвшинд авч үзэн хүүхдийн эрх ашгийг хамгаалах нь чухал гэж үзнэ.

- Хүүхдийнхээ эрхийг зөрчин доромжилж гэр орноосоо дайжуулсан эцэг эхэд нь хууль зүйн болон эдийн засгийн хариуцлага хүлээлгэдэг эрх зүйн орчин бүрдүүлнэ.

2.19. Эмэгтэйчүүдийн талаар баримтлах

бодлого чиглэл

- Хүн амын олонхи болсон эмэгтэйчүүд, эхчүүдийн эрх ашгийг дээдлэн хүндэтгэж, хөдөлмөрлөх, төр, нийгмийн удирдах, шийдвэр гаргах түвшинд ажиллуулах эрүүл мэндийг хамгаалах, сурч боловсрол эзэмших эрхийг нь эдлүүлэх, өрх толгойлсон ядуу амьдралтай, олон хүүхэдтэй эхчүүдэд, материаллаг болон эдийн засаг, оюун санааны дэмжлэг үзүүлэх, амьдралын түвшин соёл ахуйн нөхцлийг сайжруулах, мэргэжил эзэмшихтэй холбогдсон үйл ажиллагааг дэмжин туслалцаа үзүүлэх бүхий л боломжийг эрэлхийлнэ. Энэ чиглэлээр зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, нутаг дэвсгэрийн гүйцэтгэх эрх мэдэл бүхий байгууллагын санаачлагыг дэмжин хамтран ажиллана.
- Оюутан эхчүүдийн суралцах нөхцлийг хангахын тулд хүүхдийг асран саатуулах, эмчлэн сувилах, халамжийн байгууллага байгуулахыг дэмжинэ.
- Эмэгтэйчүүд, эхчүүдийн эрх ашгийг зөрчих, хүчирхийлэх, ялгаварлан гадуурхах байдлыг арилгах талаар төрийн бус болон хууль хяналтын байгууллагаас зохиож байгаа ажил санаачлагыг дэмжинэ.
- Эмэгтэйчүүд, эхчүүдийн эрх ашгийг төрийн ивээлд байлгаж, дээдлэн хүндэтгэхийн зэрэгцээ эх хүнийхээ болон иргэний үүргээ биелүүлэх хариуцлагыг нь дээшлүүлэх, хууль эрхийн мэдлэгийг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь чухал гэж үзнэ.
- Олон хүүхэд төрүүлж тэднийгээ нийгэмд, өөртөө хэрэгтэй зөв хүмүүжил, боловсролтой, хөдөлмөрч иргэн болгон төлөвшүүлсэн эхчүүдэд төрөөс үзүүлэх хүндэтгэлийг олон хэлбэртэй болгохыг чухалчилна.

2.20. Ахмад настны талаар баримтлах

бодлого, чиглэл

- Эх орны тусгаар тогтнолыг хамгаалах, бүтээн байгуулалтанд хөдөлмөр, авъяас чадвараа зориулж ирсэн ахмад үеэ дээдлэн хүндэтгэл үзүүлэх, асран хамгаалах нь төр, залуучуудын байгууллагын үүрэг гэж үзэж тэдэнд үзүүлж байгаа нийгмийн халамж, асрамж үйлчилгээг нэмэгдүүлнэ.
- Ахмад настанд үзүүлэх нийгмийн халамж, асрамж үйлчилгээний тухай хуульд заагдсан эрхийг бүрэн эдлүүлэх боломж хангана.
- Ахмад үеэ хүндэтгэх, асран тэтгэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, урам хайрлах, нийгмийн эрүүл, хүмүүнлэг уур амьсгал бүрдүүлэх зорилгоор төр, залуучуудын байгууллага 60 дээш насны ахмадуудад жилд нэг удаа / тэдний тэтгэвэр, ажиллаж байсан байгууллагаас нь хуулийн дагуу үзүүлдэг хүндэтгэлийг харгалзахгүйгээр / 50 мянгаас доошгүй төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлж байх арга хэмжээг зохион байгуулж хэвшүүлнэ.
- Ахмад хүмүүсийн эрүүл мэндийн талаар тавих анхаарал халамжийг нэмэгдүүлэх нь өрхийн эмчийн ажлын чухал үзүүлэлтийн нэг гэж үзнэ.

2.21. Үндэсний аюулгүй байдал

Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын асуудлыг хил хамгаалалт, ээвсэгт хүчний зэвсэг техникийн бүтэц, хангамж, мэргэжлийн бөлөвсөн хүчний чадвар, экосистем ба газар эзэмшилт, үндэсний эдийн засгийн бүтэц,

хөгжилт, хүн амын амьдралын түвшин, хүнсний эрүүл ахуйн нөхцөл, улс орны хэмжээнд заавал байх нөөц, түүний хангалтыг элдэв эрсдэлээс хамгаалах бодлого зохицуулалт, гадаадын цагаач иргэдийн хөдөлгөөн, суурьшил, хүн амын шүтэх, эс шүтэх эрх зүйн хэмжээ, төр, иргэн, гүйцэтгэх засаглалын бүх шатны байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага хяналт гэсэн өргөн хүрээнд авч үзэж, эдийн засаг, зохион байгуулалт, эрх зүйн нөхцлийг бүрдүүлнэ.

- Батлан хамгаалах болон аюулаас хамгаалах байгууллагын мэргэжлийн боловсон хүчин, орчин үеийн техник хангамжийн асуудалд онцгой анхаарч, үүргээ өндөр түвшинд биелүүлэх нөхцөл хангана.
- Хил хамгаалалтын асуудлыг онцгой анхаарч, мэргэшсэн албаны харуул, хамгаалалтаар бэхжүүлэх, техник хэрэгсэл болон бусад материаллаг нөхцөлөөр хангана.
- Улс орны эдийн засгийн аюулгүй байдлыг хангахын тулд түлш, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай ажиллагаа, нефть бүтээгдэхүүний хангамж, зам, харилцаа холбоо, мэдээлэлжүүлэлт зэрэг дэд бүтцийн бүрдэлт, хүн ам, армийн хүнс, тэжээлийн хангамж, эрүүл ахуйн баталгаа, үндэсний эдийн засгийн чадавхи зэргийг онцгойлон үзэж, төрийн бодлого зохицуулалтанд байлгана.
- Заавал байлгах улсын нөөцийн бүтэц, бүрдүүлэлт, хамгаалалт, нөхөн сэлбэлт ба шинэчлэлтийн асуудлыг онцгойлон үзэж үндэсний аюулгүйн зөвлөлийн байнгын хяналтанд байлгана.
- Үндэсний аюулгүй байдлын баталгаа гэдэгт үндэсний эдийн засгийн хөгжил, бүтцийн ерөнхий асуудлаас гадна цас, зуд, үөр, ус, аянга, цахилгаан, газар хөдлөлт, гал түймэр, ус бэлчээрийн нөөц, түүний ашиглалт, нөхөн сэлбэлт, хүн малын эрүүл мэнд, импортын болон хүнсний барааны эрүүл ахуйн баталгаа, мал аж ахуйг элдэв эрсдэлээс хамгаалах асуудлыг багтаан, төр, нийтийн хүч анхаарлыг төвлөрүүлж, хохирол багатайгаар даван туулахад чиглэгдсэн шинэ байдлаар авч үзэн холбогдох зохицуулалт хийж, эдийн засаг, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- Мал, газрыг эрсдэлээс хамгаалахад зориулагдсан эдийн засгийн нөхцлийг мөнгөн хөрөнгө ба материаллаг байдлаар бий болгох асуудлын эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Үндэсний аюулгүй байдал, улс орны тусгаар тогтнолыг сахин хамгаалахад төр, иргэн, гүйцэтгэх засаглалын бүх шатны болон төрийн бус байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, оролцоог тодорхойлсон эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

2.22. Батлан хамгаалах асуудал ба иргэний цэргийн үүргийн талаар баримтлах бодлого

- Эх орны тусгаар тогтнолыг хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журмыг сахин хэрэгжүүлэхийн тулд мэргэжлийн боловсон хүчин, техник хангамж, армийн бие бүрэлдэхүүний ар гэрийн амьдрал, нийгмийн баталгааг төр бүрэн хариуцах бодлого баримтална.
- Цэргийн насны залуучуудын цэргийн албан үүргээ гүйцэтгэх хугацаанд нь үйлдвэрлэл, техник мэргэжлийн боловсрол эзэмшүүлнэ.
- Цэргийн албаны үүргээ дүйцүүлэх албаны байдлаар гүйцэтгэх хүсэлтэй залуучуудыг орон нутгийн цэргийн хэлтэс, иргэний хамгаалалтын алба, Улсыг батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн төв, орон нутгийн зөвлөл, нутаг дэвсгэрийн засаг захиргааны байгууллагын хамтын зохион

байгуулалтын хүрээнд өвс тэжээл бэлтгэх, зам тавих, бэлчээр усжуулах, байгалийн гамшигтай тэмцэх, малыг эрүүлжүүлэх арга хэмжээ, хилийн ангид туслах зэрэгт ажиллуулж аль болохоор ар гэртээ дарамт хүдрэлгүй, үр дүнтэй бүтээлч байдлаар албаа хааж болох хөнгөлөлттэй нөхцөл бий болгоно.

- Батлан хамгаалах яам, хилийн цэргийн анги нэгтгэлүүдийн бүтэц зохион байгуулалтын оновчтой хэлбэрийг сонгох, материаллаг нөхцлөөр хангах зэргээр улс орны хил, хязгаар нутгийн бүрэн бүтэн байдал, ард иргэдийн тайван амьдрах нөхцлийг хамгаалан бэхжүүлэхэд чиглэсэн тодорхой алхмуудыг хэрэгжүүлнэ.
- Мал аж ахуйн өвс тэжээлийн улс, орон нутгийн фонд бэлтгэх, зам тавьж дэд бүтцийн хөгжилд хөдөлмөрлөх, бэлчээр усжуулах, хамгаалах зэргээр зохион байгуулалттай тодорхой үүрэгтэйгээр хөдөлмөр эрхлэх нь тайван цагт цэргийн албаны үүрэг биелүүлэх нөхцөл гэж үзнэ.
- Цэргийн албаны тушаалтнуудын ёс зүйн хэм хэмжээний эрх зүйн орчин бүрдүүлж, зөрчил гаргасан, цэргийн албаны үүргээ гүйцэтгэж байгаа хүмүүсийн эрхийг зөрчсөн хүмүүст ногдуулах хариуцлагыг нэмэгдүүлнэ.
- Улсын хилийг элдэв зөрчил / хилийн шугам зөрчих, үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, амгалан тайван байдал, байгаль экологид хохирол учруулахуйц мал амьтан, бараа бүтээгдэхүүн, зэвсэг хэрэгсэл, гал түймэр нэвтрүүлэх буюу элдэв зохисгүй оролдого хийх гэх мэт хууль бус үйлдлүүд /-өөс сэргийлж бүс нутгийн улс орны аюулгүй байдлыг хангах, учирсан хохирлыг хамтын хүчээр шударгаар, дипломат арга, хүмүүнлэгийн соёлтой, ухамсартай зохицуулалтаар шуурхай шийдвэрлэж, барагдуулах, энх тайвнаар, найрсгаар зэрэгцэн орших нөхцлийг баталгаажуулна. Үүний тулд Засгийн газрын шууд харъяаны хил хяналтын хэрэгжүүлэгч агентлагийг байгуулж түүний үйл ажиллагаанд Батлан хамгаалах яам, Гадаад харилцааны яам, тагнуулын ерөнхий газрын зүгээс тавих хяналт, мэргэжлийн удирдлага, тухайн бүс нутгийн туслалцаа, хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлсон эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

2.23. Гадаад бодлого

Дэлхийн олон орнуудтай олон талын хамтын ажиллагаа, найрсаг харилцааг хөгжүүлэн бэхжүүлэх, үндэсний болон улс түмний эрх ашгийг дээдлэн хүндэтгэх, дэлхий дахинд хүлээсэн үүрэг, хариуцлагаа ухамсарлан идэвхитэй ажиллах зэргээр олон улсын харилцаанд өөрийн байр суурь, нэр хүндийг хамгаалан, эрх тэгш, харилцан ашигтай үйл ажиллагаа явуулахыг гол зорилго болгоно.

- Эдийн засаг, стратегийн чиглэлтэй үйл ажиллагаанд ашиг сонирхолын зарчмыг тэнцвэржүүлэхэд чиглэгдсэн бодлого баримтална.
- Монгол Улсын болон дэлхийн улс орнуудын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг сахин хамгаалах, энх тайвнаар зэрэгцэн оршиж, бие биеийн дотоод хэрэгт оролцохгүй байх, сайн хөршийн найрсаг харилцааг хамгаалахад чиглэгдсэн үйл ажиллагаанд идэвхитэй оролцох байр суурь баримтална.
- Эх дэлхий, байгаль орчин, агаар мандал зэрэг экосистемийн зохистой бүтцийг хамгаалах, зуд, үер, аянга, газар хөдлөлт, салхи шуурга, гал түймэр гэх мэт байгалийн элдэв гамшгийг хамтын хүчээр даван

туулах, харилцан туслах гишүүнчлэлийн байр суурь эзэлж, тодорхой эрх эдлэх зэрэг үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

- Монгол Улсын иргэн гадаадад чөлөөтэй зорчих, тухайн орны иргэдтэй адил амьдарч, хөдөлмөрлөх, хөдөлмөрөө үнэлүүлэх, эрхээ хамгаалуулах эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлыг төр, засгийн хэмжээнд хэлэлцэн тохирч баталгаажуулахыг зорино.

2.24. Гадаадын зээл тусламжийн ашиглалт, түүнд тавих хяналт

Гадаад орон, олон улсын байгууллагаас авч байгаа зээл, тусламжийг ашиглах, зориулалтыг зөв сонгох, эргэн төлөгдөх нөхцлийг баталгаажуулахын тулд удирдлага, хяналтын төвлөрсөн бүтцийг бий болгож, Улсын Их Хуралд жил бүр мэдээлэл хийдэг хариуцлагын тогтолцоо бий болгоно.

- Гадаад орнууд, олон улсын байгууллагаас авч буй хөгжлийн албан ёсны зээл, тусламжийг өөрийн орны эдийн засгийн даацад тохируулан, урт хугацаатай, бага хүүтэйгээр авч, эдийн засаг, нийгмийн зайлшгүй чухал хэрэгцээнд зориулах бодлого баримтална. Үүнд: үйлдвэрлэл, боловсрол, эрүүл мэндийн салбар, дэд бүтцийг сэргээх, шинээр бий болгож хөгжүүлэх, газар эзэмшил, экосистемийн бодлого хэрэгжүүлэх, хөдөө орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжил болон байгалийн эрсдэлээс хамгаалах нөхцөл бүрдүүлэх зэрэг төрийн зохицуулалттай, түгээмэл хэрэглээтэй бодлого хэрэгжүүлэхэд түлхүү ашиглана. Гадаадын зээл тусламжийг ашиглаж байгаа объект бүрийг улсын мэдээлэлд хамруулах, зээл хүүгийн өрөө төлөх календарчилсан төлөвлөгөө боловсруулж жил бүр төсвийн төлөвлөгөөнд тусган уялдуулж байх, аж ахуйн нэгж бүрийг паспортжуулж, зээл хүүгийн төлбөр хийх график гаргаж мөрдөх зэрэг ажлыг зохион байгуулна.

2.26. Эдийн засгийг бүсчилэн хөгжүүлэх чиглэл

- Эдийн засгийг бүсчилэн хөгжүүлэх, эдийн засаг худалдааны чөлөөт бүс байгуулах асуудлыг төрөөс нэн түрүү шийдвэрлэх асуудлын хүрээнд авч үзнэ.
- Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Дорнод, Ховд, Алтанбулаг, Хөвсгөл зэрэг дэд бүтэц харьцангуй бий болсон шинээр бий болоход дөхөмтэй газруудыг эдийн засгийн чөлөөт бүс болгон газрын түрээсийн асуудлыг зөв хувилбараар уян хатнаар зохицуулах бодлогоор шийдвэрлэнэ.
- Хот, хөдөөд бөөний болон жижиглэнгийн худалдааны үр ашигтай зохион байгуулалт хийнэ. Мал аж ахуйн түүхий эдийг төвлөрүүлэн чанар сайтай бэлтгэдэг, чирэгдэл багатай тогтолцоог бий болгон түүхий эдийн үнийн урьдчилгаа олгох, бэлэн мөнгөөр худалдан авах байдлаар малчдыг мөнгөжүүлэх, үйлдвэрийг түүхий эдээр хангах үйл ажиллагааг зохион байгуулна. Энэ ажлыг орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, гүйцэтгэх засаглал, төсөв захиран зарцуулагчийн бүрэн хяналт, зохицуулалтанд хэрэгжүүлэх нь чухал гэж үзнэ.

2.27. Төрийн ба төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах

- Цалин хөлсний талаар дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэхэд үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай идэвхитэй хамтран ажиллана.
- Төрийн бус байгууллагаас төрийн үйл ажиллагаанд хяналт тавих нөхцлийг бүрдүүлж үйл ажиллагаагаа идэвхижүүлэх бүхий л боломжоор хангана.
- Төрийн зарим үүргийг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлнэ. Энэ зорилтоо хэрэгжүүлэхдээ юуны өмнө нийгмийн халамжийн чиглэлээр ажиллаж байгаа эмэгтэйчүүд, хүүхэд, тахир дутуу иргэд, ахмад настны байгууллагуудтай гэрээ байгуулна.

БҮГД НАЙРАМДАХ НАМ